



# СҮХБААТАР АЙМАГ

## СТАТИСТИКИЙН ТОВЧООН

НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖЛИЙН  
ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТЭЭР ХЭВЛЭВ.

**Боловсруулж, эмхтгэсэн:**  
**Хянан тохиолдуулсан:**

Ш. Сэржхүү, Л. Нямбат  
Б. Эрдэнэсүрэн, С. Алтанцэцэг

**Холбоо барих:**

Үндэсний Статистикийн Хороо  
Монгол улс, Улаанбаатар 14200  
Засгийн газрын III байр

**Мэдээллийн үйлчилгээ**

Утас: 1900-1212  
Факс: (976-11)-329271  
И-мэйл: [information@nso.mn](mailto:information@nso.mn)  
Вэб сайт: [www.1212.mn](http://www.1212.mn)

## ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ	6
СҮХБААТАР АЙМГИЙН ТАНИЛЦУУЛГА	8
ХҮН АМ, НИЙГЭМ	11
1. ХҮН АМ	12
2. НИЙГМИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД	19
3. БОЛОВСРОЛ, СОЁЛ	24
4. ЭРҮҮЛ МЭНД	29
5. НИЙГМИЙН ДААТГАЛ	32
6. ГЭМТ ХЭРЭГ, ШҮҮХ	33
<hr/>	
ЭДИЙН ЗАСАГ	37
7. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН	38
8. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	40
9. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ	41
10. БАНК, САНХҮҮ, ДААТГАЛ	44
11. ТӨРИЙН САНХҮҮ	47
12. ХӨДӨӨ АЖ АХУЙ	49
МАЛ АЖ АХУЙ	49
ГАЗАР ТАРИАЛАН	64
13. АВТО ТЭЭВЭР, ХАРИЛЦАА ХОЛБОО	67
14. БАРИЛГА, НИЙТИЙН АЖ АХУЙ	69
15. БАЙГАЛЬ ОРЧИН, ЦАГ УУР	71
16. ГАЗРЫН НЭГДМЭЛ САН	73

ХАВСРАЛТ-1 (сумаар)

ХАВСРАЛТ-2 (багаар)

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

ХҮСНЭГТ 1.1 АЙМГИЙН ХҮН АМ, хот, хөдөөгөөр, мянган хүн	13
ХҮСНЭГТ 1.2 СУМДЫН ХҮН АМЫН ТОО	13
ХҮСНЭГТ 1.3 ДУНДАЖ ХЭМЖЭЭНИЙ СУМ, БАГ	14
ХҮСНЭГТ 1.4 ХАМГИЙН ОЛОН ХҮН АМ, ТОМ НУТАГ ДЭВСГЭРТЭЙ СУМ, БАГ	15
ХҮСНЭГТ 1.5 СУМДЫН ӨРХ, АМ БҮЛИЙН ТОО	15
ХҮСНЭГТ 1.6 СУМДЫН ХҮН АМЫН НЯГТРАЛ	16
ХҮСНЭГТ 1.7 ХҮН АМ ЗҮЙН АЧААЛАЛ, ХҮЙСИЙН ХАРЬЦАА, сумдаар	17
ХҮСНЭГТ 1.8 ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТ	18
ХҮСНЭГТ 2.1 ӨНЧИН ХҮҮХДИЙН ТОО	19
ХҮСНЭГТ 2.2 ӨНЧИН ХҮҮХДИЙН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ, сумаар, 2010–2013 он	20
ХҮСНЭГТ 2.3 ӨНЧИН ХҮҮХДИЙН ТОО ТОГТМОЛ БУУРСАН СУМ, БАГ	20
ХҮСНЭГТ 2.4 ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭХЧҮҮДИЙН ТОО	21
ХҮСНЭГТ 2.5 ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭХИЙН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ, сумаар 2010–2013 он	21
ХҮСНЭГТ 2.6 ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭХИЙН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ, хамгийн их бууралттай ба өсөлттэй 5 баг	21
ХҮСНЭГТ 2.7 ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО	22
ХҮСНЭГТ 2.8 ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар	22
ХҮСНЭГТ 2.9 ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ТОО, ХАМГИЙН ИХ БУУРСАН, ӨССӨН БАГ	23
ХҮСНЭГТ 3.1 АЙМГИЙН БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ	25
ХҮСНЭГТ 3.2 2013–2014 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА, СУРАЛЦАГЧДЫН ТОО, сумаар	26
ХҮСНЭГТ 3.3 2013–2014 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН НИЙТ ҮНДСЭН БАГШИЙН ТОО, НЭГ БАГШИЙН АЧААЛАЛ	27
ХҮСНЭГТ 3.4 АЙМГИЙН СОЁЛЫН БАЙГУУЛЛАГЫН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ	28
ХҮСНЭГТ 4.1 АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ	30
ХҮСНЭГТ 4.2 СУМДЫН ИХ ЭМЧ, СУВИЛАГЧДЫН ТОО, АЧААЛАЛ 2013	30
ХҮСНЭГТ 4.3 АМЬД ТӨРСӨН ХҮҮХЭД БА НЯЛХСЫН ЭНДЭГ ДЭЛ	31
ХҮСНЭГТ 4.4 НАС БАРСАН ХҮН, зонхилох өвчний ангиллаар	31
ХҮСНЭГТ 4.5 ХАЛДВАРТ ӨВЧНӨӨР ӨВЧЛӨГЧИД, өвчний төрлөөр	32
ХҮСНЭГТ 5.1 АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЗҮҮЛЭЛТ	32
ХҮСНЭГТ 6.1 БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, төрлөөр	34
ХҮСНЭГТ 6.2 ХОХИРОГЧ ИРГЭД	34
ХҮСНЭГТ 6.3 ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС УЧИРСАН ХОХИРОЛ БА НӨХӨН ТӨЛҮҮЛЭЛТ, сая төгрөг	34
ХҮСНЭГТ 6.4 БҮРТГЭГДСЭН НИЙТ ГЭМТ ХЭРЭГ, сумаар	35
ХҮСНЭГТ 7.1 НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН, оны үнээр, тэрбум төг	38
ХҮСНЭГТ 7.2 ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНД АЙМАГ БОЛОН САЛБАНУУДЫН ЭЗЛЭХ ХУВЬ	39
ХҮСНЭГТ 8.1 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, сая төгрөг	40
ХҮСНЭГТ 9.1 ИНФЛЯЦИЙН 2013 ОНЫ ӨСӨЛТӨД ҮЗҮҮЛСЭН БҮЛГҮҮДИЙН НӨЛӨӨЛӨЛ	42
ХҮСНЭГТ 9.2 ӨРГӨН ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРИМ БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ДУНДАЖ ҮНЭ, сумаар	42
ХҮСНЭГТ 10.1 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, сая төгрөг	45
ХҮСНЭГТ 10.2 ХАДГАЛАМЖ, сумаар, сая төгрөг	45
ХҮСНЭГТ 10.3 МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛД ХАМРАГДСАН МАЛЧИН ӨРХ, ДААТГУУЛСАН МАЛЫН ТОО	45

ХҮСНЭГТ 10.4 МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛ, сумаар	46
ХҮСНЭГТ 11.1 АЙМГИЙН ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГО, ЗАРЛАГА, сая төг	48
ХҮСНЭГТ 12.1 МАЛЧИН ӨРХ, МАЛЧДЫН ТОО	50
ХҮСНЭГТ 12.2 МАЛЧИН ӨРХИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, нийт өрхөд харьцуулсан хувь	50
ХҮСНЭГТ 12.3 АЙМГИЙН МАЛЫН ТОО, мянган толгой	51
ХҮСНЭГТ 12.4 СУМДЫН НИЙТ МАЛЫН ТОО	52
ХҮСНЭГТ 12.5 СУМДЫН СҮРГИЙН БҮТЭЦ	53
ХҮСНЭГТ 12.6 ХЭЭЛТЭГЧ МАЛЫН ТОО	57
ХҮСНЭГТ 12.7 СҮРЭГТ ХЭЭЛТЭГЧ МАЛЫН ЭЗЛЭХ ХУВЬ	57
ХҮСНЭГТ 12.8 СУМДЫН ХЭЭЛТЭГЧИЙН ТОО, 2013	58
ХҮСНЭГТ 12.9 БОЙЖУУЛСАН ТӨЛИЙН ТОО	
А. Аймгийн дүн, мянга	58
Б. Сумаар, 2013	59
ХҮСНЭГТ 12.10 100 ЭХЭЭС БОЙЖУУЛСАН ТӨЛ	
А. Аймгийн дундаж	59
Б. Сумаар, 2013	60
ХҮСНЭГТ 12.11 СУМ, БАГИЙН ДУНДАЖ ҮЗҮҮЛЭЛТ, 2013	60
ХҮСНЭГТ 12.12 УЛСЫН НИЙТ ЗЗО СУМЫН ДОТОР ЭЗЛЭХ БАЙР, 2013 оны байдлаар	61
ХҮСНЭГТ 12.13 ХАМГИЙН ОЛОН МАЛТАЙ СУМ, 2013	61
ХҮСНЭГТ 12.14 ХАМГИЙН ОЛОН МАЛТАЙ БАГ, 2013	62
ХҮСНЭГ 12.15 ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТОО, толгой	62
ХҮСНЭГТ 12.16 ХАШАА, ХУДГИЙН ТОО	62
ХҮСНЭГТ 12.17 БЭЛЧЭЭРИЙН ДААЦ, ТЭЖЭЭЛИЙН ХҮРЭЛЦЭЭ	63
ХҮСНЭГТ 12.18 ТАРИАЛСАН ТАЛБАЙ, га	64
ХҮСНЭГТ 12.19 СУМДЫН ТАРИАЛСАН ТАЛБАЙ, га, 2013	65
ХҮСНЭГТ 12.20 ХУРААСАН УРГАЦ, тонн	66
ХҮСНЭГТ 12.21 СУМДЫН ХУРААСАН УРГАЦ, тонн, 2013	67
ХҮСНЭГТ 12.22 ГА-ГИЙН УРГАЦ	68
ХҮСНЭГТ 13.1 АВТО ТЭЭВРИЙН САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТ	68
ХҮСНЭГТ 13.2 АЙМГИЙН ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ҮЗҮҮЛЭЛТ, сая төгрөг	68
ХҮСНЭГТ 14.1 БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН ХЭМЖЭЭ, сумаар, сая төгрөг	70
ХҮСНЭГТ 14.2 АЙМГИЙН НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭ	70
ХҮСНЭГТ 15.1 СУМДЫН АГААРЫН ДУНДАЖ ТЕМПЕРАТУР, °С	71
ХҮСНЭГТ 15.2 ХУР ТУНАДАСНЫ НИЙЛБЭР, ХУР ТУНАДАСТАЙ ӨДРИЙН ТОО	72
ХҮСНЭГТ 16.1 АЙМГИЙН ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН АНГИЛАЛ	74
ХҮСНЭГТ 16.2 СУМДЫН ГАЗРЫН НЭГДМЭЛ САНГИЙН АНГИЛАЛ, мян.га	74
ХҮСНЭГТ 16.3 ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР, мян.га	75
ХҮСНЭГТ 16.4 УЛСЫН ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭНИЙ ГАЗАР, мян.га	75

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

ЗУРАГ 1. АЙМГИЙН ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖ, БАЙГАЛИЙН БҮСҮҮДЭД ХАМРАГДАХ БАЙДАЛ	9
ЗУРАГ 1.1 СУМДЫН ХҮН АМЫН ТОО	14
ЗУРАГ 1.2 НЭГ КМ <sup>2</sup> НУТАГ ДЭВСГЭРТ НОГДОХ ХҮН	16
ЗУРАГ 1.3 ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, 2010, 2013 он	17
ЗУРАГ 2.1 ӨНЧИН ХҮҮХДИЙН ТОО	19
ЗУРАГ 3.1 СУРАЛЦАГЧИД БА ҮНДСЭН БАГШ	25
ЗУРАГ 3.2 СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН БАГШИЙН АЧААЛАЛ, нэг үндсэн багшид ноогдох хүүхдийн тоо, 2013	27
ЗУРАГ 3.3 ЕБС-ИЙН ҮНДСЭН БАГШИЙН АЧААЛАЛ, нэг үндсэн багшид ноогдох суралцагчийн тоо, 2013	27
ЗУРАГ 4.1 НАС БАРСАН ШАЛТГААН, зонхилох өвчний ангиллаар, хувиар, 2013	31
ЗУРАГ 4.2 ХАЛДВАРТ ӨВЧНИЙ БҮТЭЦ, хувиар, 2010–2013 оны дүнгээр	32
ЗУРАГ 6.1 ГЭМТ ХЭРГИЙН АНГИЛАЛ, 2010–2013 оны байдлаар	33
ЗУРАГ 6.2 ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС ӨМЧИД УЧИРСАН ХОХИРЛЫН БҮТЭЦ	35
ЗУРАГ 9.1 АЙМГИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН МЭДЭЭНД ХАМРАГДДАГ СУМД	43
ЗУРАГ 11.1 АЙМГИЙН ТӨСВИЙН ТЭНЦЭЛ, тэрбум төгрөг	48
ЗУРАГ 11.2 АЙМГИЙН ТӨСВИЙН НИЙТ ЗАРЛАГЫН БҮТЭЦ, 2013	48
ЗУРАГ 12.1 МАЛЧИН ӨРХ, МАЛЧДЫН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ	50
ЗУРАГ 12.2 АЙМГИЙН МАЛЫН ТООНЫ ӨСӨЛТ, БУУРАЛТ, мян.толгой А. Хонь, ямаа	51
Б. Тэмээ, адуу, үхэр	52
ЗУРАГ 12.3 АЙМГИЙН НИЙТ МАЛД СУМДЫН ЭЗЛЭХ ХУВЬ, 2013 оны байдлаар	52
ЗУРАГ 12.4 СУМДЫН НИЙТ МАЛЫН ТООНЫ БҮЛЭГЛЭЛТ	53
ЗУРАГ 12.5 АЙМГИЙН МАЛ АЖ АХУЙН ГОЛ САЛБАР–ТЭМЭЭНИЙ АЖ АХУЙН БАЙРШИЛ, сумаар	54
ЗУРАГ 12.6 АДУУНЫ АЖ АХУЙН БАЙРШИЛ, сумаар	55
ЗУРАГ 12.7 ҮХРИЙН АЖ АХУЙН БАЙРШИЛ, сумаар	55
ЗУРАГ 12.8 ХОНИНЫ АЖ АХУЙН БАЙРШИЛ, сумаар	56
ЗУРАГ 12.9 ЯМААНЫ АЖ АХУЙН БАЙРШИЛ, сумаар	56
ЗУРАГ 12.10 СУМДЫН БЭЛЧЭЭРИЙН АЧААЛАЛ	63

## ХАВСРАЛТ ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

### ХАВСРАЛТ –1 (сумаар)

ХАВСРАЛТ 1.1 СУМЫН НУТАГ ДЭВСГЭР, ӨРХ, ХҮН АМЫН МЭДЭЭЛЭЛ	77
ХАВСРАЛТ 2.1 СУМЫН ХҮН АМЫН НИЙГМИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД	79
ХАВСРАЛТ 3.1 СУМЫН БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	84
ХАВСРАЛТ 3.2 СУМЫН СОЁЛЫН БАЙГУУЛЛАГЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	
ХАВСРАЛТ 4.1 СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	93
ХАВСРАЛТ 4.2 ТӨРӨЛТ, НАС БАРАЛТ	97
ХАВСРАЛТ 4.3 ӨВЧЛӨЛ	99
ХАВСРАЛТ 6.1 СУМЫН ГЭМТ ХЭРГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	102
ХАВСРАЛТ 6.2 ШҮҮХЭЭР ЯЛ ШИЙТГҮҮЛСЭН ХҮН	109
ХАВСРАЛТ 9.1 СУДАЛГААНД СОНГОГДСОН СУМЫН БАРААНЫ ДУНДАЖ ҮНЭ, төгрөг	110
ХАВСРАЛТ 10.1 СУМЫН ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ, сая төг	
ХАВСРАЛТ 12.1.1 МАЛЧИН ӨРХ, МАЛЧИД	116
ХАВСРАЛТ 12.1.2 СУМЫН МАЛ АЖ АХУЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	117
ХАВСРАЛТ 12.1.3 ТАРИАЛСАН ТАЛБАЙ, га–гаар	135
ХАВСРАЛТ 12.1.4 ХУРААСАН УРГАЦ, тн–оор	137
ХАВСРАЛТ 13.1 ГАР УТАС ХЭРЭГЛЭГЧДИЙН ТОО	141
ХАВСРАЛТ 14.1 СУМЫН НИЙТИЙН АЖ АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭ	140
ХАВСРАЛТ 17.1 АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТООЛЛОГО	141

### ХАВСРАЛТ–2 (багаар)

ХАВСРАЛТ 1.2 БАГИЙН ӨРХ, ХҮН АМЫН МЭДЭЭЛЭЛ	143
ХАВСРАЛТ 2.2 БАГИЙН ХҮН АМЫН НИЙГМИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД	149
ХАВСРАЛТ 12.2.1 БАГИЙН МАЛ АЖ АХУЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	155
ХАВСРАЛТ 12.2.2 БАГИЙН МАЛЧИН ӨРХ, МАЛЧДЫН ТОО	166
ХАВСРАЛТ 12.2.3 БАГИЙН МАЛЧИН ӨРХИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД	167
ХАВСРАЛТ 12.2.4 БАГИЙН ХАШАА, ХУДГИЙН ТОО, 2012 оны тооллого	173

## ТОВЧИЛСОН ҮГ

ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
МИД	Малын индексжүүлсэн даатгал
ҮСХ	Үндэсний Статистикийн Хороо
ХЭХоршоо	Хадгаламж зээлийн хоршоо
ХҮИ	Хэрэглээний үнийн индекс
ЭМЯ	Эрүүл Мэндийн Яам

## ТЭМДЭГЛЭГЭЭНИЙ ТАЙЛБАР

{ ... }	мэдээлэл байхгүй
{ 0.0 }	маш бага тоо
{ – }	гүйцэтгэл байхгүй

## ӨМНӨХ ҮГ

Монгол Улсын Засгийн газар болон Нэгдсэн үндэстний байгууллага хоорондын 2012–2016 оны хамтын ажиллагааны стратегийн баримт бичгийн “Засаглал ба хүний эрх”-ийн асуудлаар тавигдсан тэргүүлэх чиглэлийн хүрээнд төв, орон нутгийн засаг захиргааны түвшинд баримт нотолгоонд суурилсан төлөвлөгөө, төсөв боловсруулах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх чадавхи дээшилсэн байх зорилтыг дэвшүүлэн, “Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тогтолцоог бэхжүүлэх” МОН/13/201 төслийг хамтран хэрэгжүүлж байна. Үндэсний статистикийн хороо уг төслийн “Орон нутгийн статистикийн чадавхийг бэхжүүлэх нь” бүрэлдэхүүн хэсгийг хэрэгжүүлж буй юм.

Монгол Улсын бодлого боловсруулалт, төлөвлөлт, төсөвлөлтийн эрх зүйн орчныг шинэчлэх, төсвийн хөрөнгө оруулалтын удирдлага, хяналт шинжилгээний тогтолцоог үндэсний болон орон нутгийн түвшинд сайжруулах, илүү уялдаатай, зохицуулалттай болгох зорилго нь статистикийн мэдээллийг зөв ашиглах хэрэгцээг төлөвлөгчдийн өмнө гаргаж ирлээ.

ҮСХ нь статистикийн албаны 90 жилийн ой, 2014 оныг орон нутгийн статистикийн албадын чадавхийг бэхжүүлж, анхдагч мэдээллийн чанарт ахиц дэвшил гаргах жил болгох зорилтын хүрээнд албан ёсны болон захиргааны статистикийн мэдээллээс орон нутгийн түвшинд гаргах боломжтой үзүүлэлтүүдийг сонгон авч, сум, багийн түвшинд задлан боловсруулж, аймаг, нийслэлийн мэдээллийн лавлах ном болгон хэвлэн нийтэлж, хэрэглэгч та бүхэндээ хүртээж байна. Лавлах нь орон нутгийн төлөвлөгчдийн мэдээллийн олдоц хүртээмжийг нэмэгдүүлж, өргөжүүлэхийн зэрэгцээ, сум, багийн үзүүлэлтийг аймаг, улсын дундаж үзүүлэлттэй зэрэгцүүлж харьцуулалт хийх боломжийг олгож буй юм.

Мэдээллийн лавлах нь хүн ам, нийгэм болон эдийн засаг гэсэн үндсэн бүрэлдэхүүнтэй бөгөөд дотроо дэд салбарт хуваагдаж байна. Холбогдох салбар бүрийн өмнө статистикийн үзүүлэлтүүдийг тооцох товч арга зүйн тайлбар оруулж, танилцуулгыг хүснэгт, диаграммын хамт хийж, сум, багаар харуулсан үзүүлэлт бүхий хүснэгтүүд хавсаргав. Энэхүү мэдээллийн лавлах номонд тусгагдаж буй бүх үзүүлэлтийг баг, хороо хүртэл задалж хийх эрмэлзэл зорилго тавьсан боловч өнөөдрийн нөхцөлд тусгайлсан тооллого явуулдаг хүн ам, хөдөө аж ахуйгаас бусад салбарт тэр бүр мэдээллийг задалж харуулах боломж хараахан бүрдээгүй байна. Гэвч статистикийн албанд байгаа тооллогын дүн, мэдээлэлд үндэслэн нийгэм, эдийн засгийн нэлээд үзүүлэлтийг сум, багаар бэлтгэж оруулаа.

Манай орны дундаж хэмжээний сум, баг гэж юу болох, тэдгээр нь хэдэн хүн амтай, ямар хэмжээний нутаг дэвсгэртэй, хэдэн малчин, хичнээн мал сүрэг өсгөн үржүүлдэг, тэрчлэн хамгийн том болон хамгийн бага гэгдэх сум, багийн үзүүлэлттэй өөрсдийн сум, багийн үзүүлэлтийг зэрэгцүүлж үзэх боломжийг та бүгдэд олгож байна. Аймгуудын сум, баг бүр улсад малынхаа нийт тоо болон төрлөөр хэддүгээр байранд ордог болохыг харуулав.

Өрх, хүн ам, өнчин хүүхэд, өрх толгойлсон эхчүүд зэрэг нийгмийн зарим үзүүлэлт сум, багаар, боловсрол, эрүүл мэнд, гэмт хэрэг, гол нэр төрлийн барааны үнэ, хадгаламж, зээл, төсвийн орлого, зарлага, даатгал, барилга угсралт сумаар, малчин өрх, малчдын тоо, тэдний нийгэм, соёлын зарим үзүүлэлт, нийт мал, хээлтэгч мал, бойжуулсан төлийн тоо сум, багаар, хашаа, худаг, тариалсан талбай, хураасан ургацын хэмжээг сумаар хавсралт хүснэгтэд тусгаж харуулаа.

Танилцуулга, хавсралт хүснэгтийн мэдээллийг ашиглан улс, аймаг, сум, бүс нутагт өөрсдийн эзлэх байр суурийг тодорхойлж, орон нутгийн цаашдын хөгжлийн төлөвлөлтөд нэгэн тулгуур эх сурвалж болгон ашиглагдана гэж найдаж байна.

Хүн амын үзүүлэлтийг тооллого явагдсан 1989, 2000, 2010 онууд болон 2012, 2013 оны мэдээллээр, хөдөө аж ахуйн салбарыг 1990, 2000, 2010, 2012, 2013 онуудын тооллогын дүнг үндэслэн гаргаж, бусад салбарын үзүүлэлтийг 2010–2013 оноор харуулсан болно. Сум бүрийн малын тоог төрлөөр, 24 жил дараалсан 1990–2013 онуудаар бэлтгэж оруулав.

Аймгийн мэдээллийн лавлах нь орон нутгийн удирдлага, төлөвлөгчдийн ажилд үнэтэй мэдээллийн эх үүсвэр болно гэдэгт итгэлтэй байна.

МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ  
ДАРГА

 С.МЭНДСАЙХАН

## СҮХБААТАР АЙМГИЙН ТАНИЛЦУУЛГА

**Аймгийн товч түүх.** Сүхбаатар аймгийн нутаг дэвсгэр нь 1921 оноос өмнө Халхын Сэцэн хан аймгийн Чин ван хошуу, Далай ван хошуу, Ёст бэйс хошуу, Эрх гүн хошуу, Хурц засаг хошуу, Егүзэр хутагтын шавь хошуу гэсэн 6 хошууны нутагт багтаж байв. 1931 онд Халхын 4 аймгийг 13 аймаг болгон өөрчлөхөд Хэнтий, Дорнод аймагт харъяалагдаж байлаа. БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1941 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн 81-р тогтоолоор Дорнод аймгаас Дарьганга, Хонгор, Баяндэлгэр зэрэг 10 сум, Хэнтий аймгаас Баянтэрэм, Өлзийт зэрэг 4 сум бүгд 14 сумтай Жавхлант шарга аймгийг 1942 онд анх байгуулжээ. БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1943 оны 2-р сарын 20-ны 8-р тогтоолоор Жавхлант шарга аймгийг их жанжин Сүхбаатарын нэрэмжит болгож “Сүхбаатар аймаг” гэж нэрлэх болсон. Мөн ондоо аймгийн төвийг Баруун-Урт голын дэргэд шилжүүлэн суурьшуулж “Баруун-Урт” гэж нэрлэсэн байна.

Сүхбаатар аймаг нь манай улсын зүүн өмнөд хэсэгт 82.3 мянган км<sup>2</sup> талбай эзэлдэг. Газар нутаг нь тал хээрийн бүсэд багтах жижиг толгод, өргөн уудам хөндий, тэгш тал, элсэн говь зэрэг гадаргуутай юм. Аймгийн дэвсгэр нутагт нуур 31, гол 12, булаг шанд 2929, уурхайн худаг 2000 гаруй, өрөмдмөл худаг 150 орчим бий.

Ан агнуурын ач холбогдол бүхий цагаан зээр, тарваганы нутагшил нэлээд тархмал байдаг бөгөөд үнэг, чоно, үен, хярс, өмхий хүрэн, мануул, дорго, туулай, зурам, шилүүс, илбэнх, хар сүүлт зэрэг ан амьтан нутагшдаг. Эрдэнэцагаан сумын Лхачинвандад, баруун, зүүн Раатын уул, Далан тавын айрагт буга, гахай, Хар ямаат, Цав зэрэг газарт бор гөрөөс нутагшсан байдаг.

Аймгийн төв Баруун-Урт сум нь Улаанбаатар хотоос 550 км, Дорнод аймгаас 210 км, Хэнтий аймгаас 230 км, Дорноговь аймгаас 340 км-т оршдог. Өндөр хүчдэлийн шугам, асфальтан замаар холбогдсон.

**Нутаг дэвсгэр, засаг захиргааны нэгж.** Тус аймаг нь 13 сум, 67 багтай, 60 орчим мянган хүн амтай. Хүн амын олонхи нь Халх, Дарьганга ястан бөгөөд Үзэмчин, Барга, Хуучид, Өөлд, Цахар ястан цөөнх хувийг эзэлдэг. Нутгийн хилийн нийт урт 1340 км бөгөөд урд талаараа БНХАУ-тай 485 км, баруун талаараа Дорноговь аймагтай 165 км, хойт талаараа Хэнтий аймагтай 260 км, зүүн хойт талаараа Дорнод аймагтай 430 км газраар тус тус хиллэдэг.

Сүхбаатар аймаг нь нутаг дэвсгэр, хүн ам, малын тоогоор манай дундаж аймгийн тоонд орно. Аймгийн ихэнхи сум тал хээрийн байгалийн бүсэд хамрагдах бөгөөд зөвхөн Баяндэлгэр, Түвшинширээ сум говийн бүсэд орно. Аймгийн нийт нутгийн 92.8 хувийг бэлчээр, 1.0 хувийг хадлангийн талбай эзэлдэг.

Аймгийн нийт нутаг далайн түвшнээс 675–1777 метрийн өндөрт өргөгдсөн, төрийн тахилгат Дарь-Овоо (1349), Шилийн богд уул (1777) зэрэг сайхан уулстай.

### Ганга нуур



Төрийн тахилгат Алтан дарь овоо

Зотолхаан уул




Шилийн богд уул

Молцог элс

Төрийн албан хаагчдын мөргөж сүсгэлдэг Дарханхаан уул

**ЗУРАГ 1. АЙМГИЙН ЗАСАГ ЗАХИРГААНЫ НЭГЖ, БАЙГАЛИЙН БҮСҮҮДЭД ХАМРАГДАХ БАЙДАЛ**



**Байгаль, газар зүйн нөхцөл, эдийн засгийн боломж.** Тус аймаг нь манай орны бэлчээрийн ба хадлангийн нөөц сайтайд тооцогдох тал хээрийн байгалийн бүсэд хамрагдана. Мал аж ахуйг нийт сумдад өсгөн үржүүлэх, газар тариаланг Түмэнцогт зэрэг зарим суманд эрхлэн хөгжүүлэх бүрэн боломжтой юм. Нутгийн шилмэл омгийн Баяндэлгэрийн улаан ямаа, Эрдэнэцагааны үзэмчин хонь, Түмэнцогтын махны хэвшлийн үхэр, хурдан удмын адуун сүргээрээ алдартай аймаг юм. Уул уурхайн хувьд цайр, зэс молибден, хүрэн нүүрс, хайлуур жонш, гянт болд зэрэг ашигт малтмалын нөөц бүхий орд газруудтай.

2013 оны байдлаар 258.2 тэрбум төгрөгийн дотоодын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэсний 44.2 хувь нь хөдөө аж ахуйд, 35.3 хувь нь аж үйлдвэр, уул уурхайд, 4.8 хувь нь худалдаа, үйлчилгээнд, 10.0 хувь нь бусад үйлчилгээний салбарт ногдож байна. Аймгуудын дотоодын нийт бүтээгдэхүүний 1.5 хувийг тус аймагт үйлдвэрлэдэг.

**Аймгийн статистикийн алба.** БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1960 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн зарилгаар БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх Тоо бүртгэлийн улсын төв газрыг байгуулан, аймаг, хотын 19 товчоо, сумдын 389 байцаагчтай статистикийн бүхэл бүтэн цогц алба Монгол Улсын түүхэнд анх удаа бүрэлдэн тогтсон түүхтэй юм.

Аймгийн Статистикийн хэлтсийн анхны даргаар Д.Жагдар 13 жил, дараа нь М.Сүхбаатар 14 жил, О.Цэрэндулам 24 жил тогтвор суурьшилтай ажиллаж байсан байна. Одоо Т.Эрдэнэбат даргатай хамт олон ажиллаж байна.



Зүүн гар талаас: Өвөр эгнээ: Ахлах мэргэжилтэн Ц.Хад, мэргэжилтэн Э.Анхцэцэг, хэлтсийн дарга Т.Эрдэнэбат, мэргэжилтэн О.Ундрах  
Ар эгнээ: Судлаач Б.Мөнхзул, Н.Хонгорзул, мэргэжилтэн Ц.Алтанцэцэг, судлаач Б.Уянганям, нягтлан бодогч Ц.Азжаргал, жолооч М.Бөхбат

# ХҮН АМ, НИЙГЭМ

ХҮН АМ

НИЙГМИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

БОЛОВСРОЛ, СОЁЛ

ЭРҮҮЛ МЭНД

НИЙГМИЙН ДААТГАЛ

ГЭМТ ХЭРЭГ, ШҮҮХ

## 1. ХҮН АМ

Хүн амын статистикийн мэдээллийн үндсэн эх үүсвэр нь 10 жил тутамд явуулдаг хүн ам, орон сууцны тооллого, хүн амын ердийн болон шилжих хөдөлгөөний жил бүрийн мэдээ, тайлан болно.

Хүн ам	Тухайн засаг захиргааны нэгжийн нутаг дэвсгэрт байгаа бүх хүнийг хэлнэ.
Хүн амын нягтрал	Нэгж газар нутагт ногдох хүн амын тоогоор тодорхойлогдоно.
Хүн ам зүйн ачаалал	Хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох 15 наснаас доош, 65 наснаас дээш насны тэжээгдэгчийн тоог хэлнэ.
Ердийн цэвэр өсөлт	Төрөлт, нас баралтын абсолют зөрүүгээр тодорхойлно.
Хотын хүн ам	Улаанбаатар хот, аймгийн төв, тосгонд оршин суугаа хүн амыг хамруулна.
Хөдөөгийн хүн ам	Сумын төв, хөдөө амьдарч байгаа хүн амыг хамруулна.
Өрх	Нэг орон байранд хамт амьдардаг, нэгдмэл төсөвтэй, хүнс, амьдралын наад захын хэрэгцээгээ хамтран хангадаг хэсэг бүлэг хүмүүсийг хэлнэ.
Төрөлт	Хувь хүн, хосууд, хүн төрөлхтний дунд явагдаж байгаа нөхөн үржихүйн бодит үзэгдэл бөгөөд амьд төрсөн хүүхдийн тоогоор хэмжигдэнэ.
Дундаж наслалт	Насны бүлэг дэх нас баралтын коэффициентийг үндэслэн тооцсон тухайн хүний цаашид амьдрах дундаж хугацаагаар тодорхойлогддог.
Гэрлэлт	18 насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хүмүүс сайн дурын, чөлөөтэй, тэгш эрхийн үндсэн дээр гэр бүл болох зорилгоор төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлэхийг хэлнэ.
Гэр бүл	Гэрлэлтийн үр дүнд буй болсон амины болон эд хөрөнгийн эрх үүргээр холбогдсон хамтын амьдрал бүхий хүмүүсийг гэр бүл гэж хэлнэ.
Гэрлэлт цуцлалт	Гэрлэлтийн эрх зүйн харилцаа дуусгавар болох өөрөөр хэлбэл төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлж гэр бүл болсон хосууд энэ харилцаагаа цуцлахыг хэлнэ.
Үрчлэлт.	Бусдын хүүхдийг холбогдох хуулийн дагуу өөрийн хүүхэд болгон тэжээж өсгөх явц юм. Энэ бүлэгт Сүхбаатар аймгийн хүн амын тоо, хүн амын өсөлт, өрх, нас, хүйсийн бүтэц, төрөлт, нас баралт, гэрлэлт, цуцлалт, үрчлэлт зэрэг үзүүлэлтүүдийг сум, багийн түвшинд бэлтгэж орууллаа.

**Хүн ам, өрх.** Сүхбаатар аймгийн хүн амын тоо 2013 оны эцсийн байдлаар 53.1 мянга болж, өмнөх оныхоос 2.5 хувь буюу 699 хүнээр, 1989 оныхоос 2800 хүнээр өсчээ. Аймгийн хүн амын 72.7 хувь хөдөөд, 27.3 хувь хотод амьдарч байна.

### ХҮСНЭГТ 1.1 АЙМГИЙН ХҮН АМ, хот, хөдөөгөөр, мянган хүн

Сум	1989	2000	2010	2011*	2012*	2013*	2013/1989%
Бүгд	50.8	56.2	51.4	51.8	52.6	53.1	104.5
Үүнээс: Хотын	18.0	15.1	16.2	13.9	14.1	14.5	80.5
Хөдөөгийн	32.8	41.0	35.2	37.9	38.5	38.6	117.7
Эзлэх хувь: Хотын	35.4	26.7	31.6	26.8	26.8	27.3	77.1
Хөдөөгийн	64.6	73.3	68.4	73.2	73.2	72.7	112.5

\* 2010 оны ХАОСТ-д үндэслэн тооцов.

Сумын нутаг дэвсгэр, хүн ам, өрхийн мэдээлэл хавсралт 1.1-д  
Багийн хүн ам, өрхийн мэдээлэл хавсралт 1.2-т


2013 онд Баруун-Урт сумын хүн амын тоо 18.3 мянга, хөдөөгийн сумдаас Мөнххаан, Баяндэлгэр, Эрдэнэцагаан сумдын хүн ам 4.3–6.5 мянгад хүрч, аймгийнхаа том сумдын тоонд орж байна. Сүхбаатар, Баяндэлгэр, Дарьганга, Мөнххаан, Эрдэнэцагаан сумдын хүн ам 1989 оныхоос 26.0–38.0 хувиар өсчээ.

### ХҮСНЭГТ 1.2 СУМДЫН ХҮН АМЫН ТОО

Сум	1989	2000	2010	2012*	2013*	2013/1989%
Баруун-Урт	16547	15133	16150	17463	18228	110.2
Асгат	1681	1891	1690	1752	1734	103.2
Баяндэлгэр	3577	4681	4272	4614	4597	128.5
Дарьганга	2176	2694	2677	2856	2852	131.1
Мөнххаан	3215	4691	3657	4269	4295	133.6
Наран	1507	1804	1457	1550	1537	102.0
Онгон	3195	3959	3304	3655	3650	114.2
Сүхбаатар	2497	3170	2971	3178	3145	126.0
Түвшинширээ	2661	3375	2780	3017	3074	115.5
Түмэнцогт	2734	2850	2039	2391	2342	85.7
Уулбаян	3143	3888	2423	2780	2772	88.2
Халзан	1764	1883	1372	1596	1595	90.4
Эрдэнэцагаан	4734	6147	6299	6527	6526	137.9

\* Тухайн жилийн суурин хүн ам, ХА-3 мэдээгээр

ЗУРАГ 1.1 СУМДЫН ХҮН АМЫН ТОО



**Дундаж, болон том, бага сум, баг.** Улсын хэмжээгээр нэг сум дундажаар 3.0 мянган хүн амтай, 4.7 мянган км<sup>2</sup> нутаг дэвсгэртэй байгаа бол Сүхбаатар аймагт сум дундажаар 2.9 мянган хүнтэй, 6.3 мянган км<sup>2</sup> нутаг дэвсгэртэй байна.

Улсын дундажаар нэг баг 0.6 мянган хүн амтай, 1.0 мянган км<sup>2</sup> нутагтай байхад Сүхбаатар аймагт энэ үзүүлэлт 0.6 мянган хүнтэй, 1.2 мянган км<sup>2</sup> нутаг дэвсгэртэй байна.

ХҮСНЭГТ 1.3 ДУНДАЖ ХЭМЖЭЭНИЙ СУМ, БАГ

	Нэг сумын дундаж		Нэг багийн дундаж	
	Улс	Сүхбаатар аймаг	Улс	Сүхбаатар аймаг
Хүний тоо, мянга*	3.0	2.9	0.6	0.6
Нутаг дэвсгэр, мянган км <sup>2</sup>	4.7	6.3	1.0	1.2

\* Хөдөөгийн хүн амаар тооцсон

Улсын хэмжээгээр хамгийн олон хүн амтай сум бол 25.7 мянган хүнтэй Сэлэнгэ аймгийн Мандал, хамгийн цөөн хүнтэй сум нь 945 хүнтэй Завхан аймгийн Асгат сум болно. Тус аймгийн хамгийн олон хүн амтай сум бол 6526 хүнтэй Эрдэнэцагаан (аймгийн төвийн сумыг тооцоогүй), хамгийн цөөн хүнтэй сум нь 1537 хүнтэй Наран сум юм.

Дорнод аймгийн Халхгол сум улсдаа хамгийн том буюу 28.7 мянган км<sup>2</sup> нутагтай бол Дархан-Уул аймгийн Шарын гол сум 95.9 км<sup>2</sup> буюу хамгийн бага нутагтайд орно. Сүхбаатар аймгийн хувьд 16948 км<sup>2</sup> нутагтай Эрдэнэцагаан сум хамгийн том, 2135 км<sup>2</sup> нутагтай Түмэнцогт сум хамгийн бага нутагтайд тооцогдоно.

Улсын дундажаар нэг баг 609 хүн амтай, 1.0 мянган км<sup>2</sup> нутагтай байхад Сүхбаатар аймагт энэ үзүүлэлт 611 хүнтэй, 1.23 мянган км<sup>2</sup> нутаг дэвсгэртэй байна. Мөнххаан сумын Баясгалант баг 351 өрхийн 1158 хүн амтай аймгийнхаа хамгийн том баг бол Халзан сумын Сахиулшанд баг 64 өрхийн 212 хүнтэй хамгийн бага баг болж байна.

## ХҮСНЭГТ 1.4 ХАМГИЙН ОЛОН ХҮН АМ, ТОМ НУТАГ ДЭВСГЭРТЭЙ СУМ, БАГ

Үзүүлэлт	Улсын хэмжээнд	Сүхбаатар аймаг		
Хамгийн олон хүнтэй сум, хүний тоо, мян.хүн	Сэлэнгэ аймгийн Мандал	25.6	Эрдэнэцагаан	6.5
Хамгийн цөөн хүнтэй сум, хүний тоо, мян.хүн	Завхан аймгийн Асгат	0.9	Наран	1.5
Хамгийн том нутагтай сум, мян.км <sup>2</sup>	Дорнод аймгийн Халхгол	28.7	Эрдэнэцагаан	16.9
Хамгийн бага нутагтай сум, мян.км <sup>2</sup>	Дархан-Уул аймгийн Шарын гол	0.1	Түмэнцогт	2.1
Хамгийн олон хүнтэй баг, хүний тоо, мян.хүн	Дорноговь, Замын-Үүдийн 2-р баг	6.2	Мөнххаан сумын Баясгалант баг	1.2
Хамгийн цөөн хүнтэй баг, хүний тоо, мян.хүн	Өмнөговь, Ханбогдын Хайрхан баг	0.1	Халзан сумын Сахиулшанд баг	0.2

**Өрх.** 2013 онд аймгийн нийт өрхийн тоо 16.4 мянга болж, өмнөх оныхоос 2.7 хувиар нэмэгдсэн байна. Аймгийн дундажаар нэг өрхийн хүн ам 3.43 байгаа бөгөөд Түмэнцогт, Баруун-Урт, Мөнххаан, Сүхбаатар сумдад аймгийн дундажаас цөөн буюу 3.23–3.42 хүн, бусад 9 суманд аймгийн дундажаас олон буюу 3.44–3.71 хүнтэй байгаа юм.


## ХҮСНЭГТ 1.5 СУМДЫН ӨРХ, АМ БҮЛИЙН ТОО

Сум	2013 оны нийт өрхийн тоо	Нэг өрхийн ам бүлийн тоо			2013/2012 %
		2010	2012	2013	
АЙМГИЙН ДҮН	16413	3.61	3.48	3.43	98.6
Баруун-Урт	5562	3.71	3.31	3.28	99.1
Асгат	478	3.64	3.67	3.63	99.0
Баяндэлгэр	1264	3.69	3.71	3.64	98.1
Дарьганга	828	3.36	3.54	3.44	97.3
Мөнххаан	1284	3.51	3.42	3.35	97.9
Наран	438	3.43	3.61	3.51	97.1
Онгон	1002	3.63	3.73	3.64	97.8
Сүхбаатар	919	3.60	3.50	3.42	97.9
Түвшинширээ	894	3.55	3.46	3.44	99.3
Түмэнцогт	724	3.20	3.24	3.23	99.8
Уулбаян	801	3.40	3.51	3.46	98.7
Халзан	459	3.61	3.47	3.47	100.2
Эрдэнэцагаан	1760	3.82	3.75	3.71	98.9

**Хүн амын нягтрал.** Нэг 1 км<sup>2</sup> нутаг дэвсгэрт улсын дундажаар 1.9 хүн амьдардаг бол тус аймагт 0.7 хүн ногдож байна. Асгат, Сүхбаатар сум нь бусдаас хамгийн цөөн буюу 1 км<sup>2</sup> нутаг дэвсгэрт 0.24 хүн ногдож байхад аймгийн төв-Баруун-Урт суманд хамгийн олон буюу 328 хүн, Түмэнцогт суманд 1.09 хүн, бусад сумдад 0.38–0.60 хүн ногдож байна.


## ХҮСНЭГТ 1.6 СУМДЫН ХҮН АМЫН НЯГТРАЛ

Сум	Нутаг дэвсгэр, км <sup>2</sup> , 2013	Хүн амын нягтрал (1 км <sup>2</sup> нутаг дэвсгэрт ногдох хүн ам)			2013/2012 %
		2010	2012	2013	
АЙМГИЙН ДҮН	82287.2	0.61	0.67	0.68	101.3
Баруун-Урт	54.5	290.54	314.16	327.93	104.4
Асгат	7198.0	0.23	0.24	0.24	99.0
Баяндэлгэр	7881.9	0.56	0.60	0.60	99.6
Дарьганга	4814.1	0.55	0.59	0.59	99.9
Мөнххаан	7415.1	0.49	0.57	0.58	100.6
Наран	3523.0	0.43	0.46	0.45	99.2
Онгон	6468.4	0.47	0.52	0.52	99.9
Сүхбаатар	12761.9	0.23	0.25	0.24	99.0
Түвшинширээ	4356.2	0.63	0.68	0.69	101.9
Түмэнцогт	2134.6	0.95	1.11	1.09	98.0
Уулбаян	4945.1	0.49	0.56	0.56	99.7
Халзан	3786.7	0.36	0.42	0.42	99.9
Эрдэнэцагаан	16947.8	0.37	0.38	0.38	100.0

ЗУРАГ 1.2 НЭГ КМ<sup>2</sup> НУТАГ ДЭВСГЭРТ НОГДОХ ХҮН

**Хүн амын нас, хүйсийн бүтэц.** 2013 оны байдлаар Сүхбаатар аймгийн хүн амын 50.1 хувь буюу 28.2 мянга нь эрэгтэй, 49.9 хувь буюу 28.1 мянга нь эмэгтэй байна. Хүн амыг насны бүлгээр авч үзвэл 37.3 хувийг 19 хүртэлх насны хүүхэд, 57.1 хувийг 20–59 насны хүн ам, 5.6 хувийг 60 ба түүнээс дээш насны өндөр настнууд эзэлж байна.

ЗУРАГ 1.3 ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, 2010, 2013 он



Аймгийн хүний дундаж наслалт 71.19 буюу 71 нас болжээ.

Аймгийн хүн ам зүйн ачаалал 2013 онд хөдөлмөрийн насны 100 хүнд тэжээлгэгч 51.4 хүн ногдож, мөн хүйсийн харьцаа ойролцоо буюу 100 эмэгтэйд 100.3 эрэгтэй ногдож байна. Сумдаар авч үзвэл Түмэнцогт, Баруун-Урт сумдад 100 эмэгтэйд 96.1–96.5 эрэгтэй, бусад сумдад 98.9–104.8 эрэгтэй ногдож байна.

ХҮСНЭГТ 1.7 ХҮН АМ ЗҮЙН АЧААЛАЛ, ХҮЙСИЙН ХАРЬЦАА, сумдаар

Сум	2010		2012		2013	
	Хүн ам зүйн ачаалал	Хүйсийн харьцаа	Хүн ам зүйн ачаалал	Хүйсийн харьцаа	Хүн ам зүйн ачаалал	Хүйсийн харьцаа
АЙМГИЙН ДУНДАЖ	53.7	104.1	50.8	100.3	51.4	100.3
Баруун-Урт	48.4	99.2	48.4	96.6	50.6	96.5
Асгат	49.7	113.1	47.0	100.5	46.0	102.8
Баяндэлгэр	58.6	102.3	53.2	101.1	53.3	100.8
Дарьганга	58.0	100.7	51.8	100.4	51.1	98.9
Мөнххаан	62.0	101.3	55.9	99.9	55.1	101.1
Наран	48.1	107.8	44.6	100.8	43.8	99.6
Онгон	58.5	102.6	54.3	101.7	53.7	102.4
Сүхбаатар	50.3	119.6	51.2	103.1	51.3	104.4
Түвшинширээ	58.4	107.6	54.6	104.4	54.1	104.8
Түмэнцогт	59.0	99.5	48.2	99.1	50.1	96.1
Уулбаян	53.4	108.0	46.5	105.6	47.8	104.1
Халзан	52.6	106.0	46.6	99.7	47.3	100.9
Эрдэнэцагаан	56.5	110.7	54.5	104.6	54.1	104.6

**Хүн амын ердийн хөдөлгөөн.** 2013 онд тус аймагт 1224 хүүхэд төрж, 388 хүн нас барж, хүн амын цэвэр өсөлт 836 хүн байв. 2013 онд хүн амын цэвэр өсөлт өмнөх жилээс 23.7 хувиар буурсны 60–аад хувь нь тус аймагт төрөлт багассантай, 40 хувь нь нас баралт өссөнтэй холбоотой байна. Төрсөн эхчүүдийн 87.6 хувь нь гэр бүлтэй байгаа нь улсын дундажаас 1.8 пүнктээр дээгүүр байна.

Нийт 434 хос 2013 онд гэрлэлтээ бүртгүүлж, 36 гэр бүл гэрлэлтээ цуцлуулж, 46 хүүхэд үрчлэгджээ. Гэрлэлт өмнөх оныхоос 26.2 хувь, гэр бүл цуцлалт 2 дахин, хүүхэд үрчлэлт 12.2 хувь өссөн байна. 1000 хүн тутамд 11.7 гэрлэлт, 1.0 цуцлалт, 0.9 үрчлэлт ногдож байна.

#### ХҮСНЭГТ 1.8. ХҮН АМЫН ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТ

Үзүүлэлт	1989	2000	2010	2012	2013	2013/2012 %
Төрсөн хүүхдийн тоо	1953	1028	1218	1375	1224	89.0
Нас барсан хүний тоо	421	281	367	280	388	138.6
Ердийн цэвэр өсөлт	1532	747	851	1095	836	76.3
Гэрлэлт	296	241	239	344	434	126.2
Цуцлалт	1	2	20	18	36	200.0
Үрчлэгдсэн хүүхдийн тоо	–	–	51	41	46	112.2
1000 хүнд ногдох: Төрөлт	37.9	18.4	22.2	26.3	23.1	87.8
Нас баралт	8.2	5.0	6.7	5.4	7.3	135.2
Цэвэр өсөлт	29.7	13.4	15.5	21.0	15.8	75.2
Гэрлэлт	4.0	3.2	6.6	9.4	11.7	124.5
Цуцлалт	0.0	0.0	0.6	0.5	1.0	200.0
Үрчлэлт	–	–	0.9	0.8	0.9	112.5

## 2. НИЙГМИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өрх толгойлсон эмэгтэйчүүд	Өрх толгойлон амьдарч байгаа эмэгтэйчүүдийг хүүхэдтэй эсэхийг харгалзахгүйгээр хамруулна.
Бүтэн ба хагас өнчин хүүхэд	Эцэг, эх нь хоёулаа нас барсан хүүхдийг бүтэн өнчинд, эцэг, эх хоёрын аль нэг нь нас барсан хүүхдийг хагас өнчинд тооцно.
Энэ бүлэгт өнчин хүүхэд, өрх толгойлсон эх, өрх үүсгэн ганцаар амьдарч буй настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээллийг сум, багийн түвшинд бэлтгэж орууллаа.	

**Өнчин хүүхэд.** Сүхбаатар аймагт өнчин хүүхдийн тоо 2013 оны эцсийн байдлаар 692 болж өмнөх оныхоос 6.5 хувь буюу 48-аар буурсан байна. Бүтэн ба хагас өнчин хүүхэд аль аль нь буурсан байна. 2013 онд нийт өнчин хүүхдийн 5.8 хувь нь бүтэн өнчин, 94.2 хувь нь хагас өнчин хүүхэд байна.


ХҮСНЭГТ 2.1 ӨНЧИН ХҮҮХДИЙН ТОО

Сум	2010	2011	2012	2013	2013/2012 %
Бүгд	827	736	740	692	93.5
<b>Үүнээс:</b> Бүтэн өнчин	52	53	44	40	90.9
Хагас өнчин	775	683	696	652	93.7
<b>Эзлэх хувь:</b> Бүтэн өнчин	6.3	7.2	5.9	5.8	
Хагас өнчин	93.7	92.8	94.1	94.2	

Сумын нийгмийн зарим үзүүлэлтүүд хавсралт 2.1-д  
Багийн нийгмийн зарим үзүүлэлтүүд хавсралт 2.2-т

Аймгийн дүнгээр сүүлийн 4 жилийн байдлаар өнчин хүүхдийн тоо буурах хандлагатай байна.

ЗУРАГ 2.1 ӨНЧИН ХҮҮХДИЙН ТОО



**Өнчин хүүхдийн тоо тогтмол буурсан сум, баг.** Өнчин хүүхдийн тоо аймгийн дундажаар жилд 5.77 хувь буурсны дотор Халзан, Наран, Түмэнцогт, Сүхбаатар сумын өнчин хүүхдийн тоо 2010–2013 онуудад жилд дундажаар 15.30–33.50 хувь буурсан бол, харин Асгат, Баяндэлгэр суманд жилд дундажаар 5.90–12.83 хувь өссөн байна.

## ХҮСНЭГТ 2.2 ӨНЧИН ХҮҮХДИЙН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ, сумаар, 2010–2013 он

Сум	2010	2011	2012	2013	2011/2010%	2012/2011%	2013/2012%
АЙМГИЙН ДҮН	827	736	740	692	89.0	100.5	93.5
Халзан	17	14	11	5	82.4	78.6	45.5
Наран	22	13	13	7	59.1	100.0	53.8
Түмэнцогт	49	32	25	28	65.3	78.1	112.0
Сүхбаатар	79	56	42	48	70.9	75.0	114.3
Эрдэнэцагаан	139	129	119	111	92.8	92.2	93.3
Мөнххаан	57	59	59	46	103.5	100.0	78.0
Баруун–Урт	195	197	199	158	101.0	101.0	79.4
Дарьганга	47	26	32	41	55.3	123.1	128.1
Түвшинширээ	52	46	53	49	88.5	115.2	92.5
Онгон	47	47	55	46	100.0	117.0	83.6
Уулбаян	36	34	48	36	94.4	141.2	75.0
Асгат	32	25	20	38	78.1	80.0	190.0
Баяндэлгэр	55	58	64	79	105.5	110.3	123.4

2010–2013 оны хооронд Халзан, Эрдэнэцагаан сумын өнчин хүүхэд тогтмол буурч ирсэн бөгөөд Мөнххаан сумын Баясгалант, Түмэнцогт сумын Баян–Овоо, Уулбаян сумын Дэлгэр, Эрдэнэцагаан сумын Жаргалант багуудын өнчин хүүхэд мөн тогтмол буурсан байна. Харин 2010–2013 оны хооронд Баяндэлгэр сумын өнчин хүүхдийн тоо тогтмол өссөн байна.

## ХҮСНЭГТ 2.3 ӨНЧИН ХҮҮХДИЙН ТОО ТОГТМОЛ БУУРСАН СУМ, БАГ

Сум, баг	2010	2011	2012	2013	2011/2010%	2012/2011%	2013/2012%
<b>Сум:</b> Халзан	17	14	11	5	82.4	78.6	45.5
Эрдэнэцагаан	139	129	119	111	92.8	92.2	93.3
<b>Баг:</b> Мөнххааны Баясгалант	23	14	10	8	60.9	71.4	80.0
Түмэнцогтын Баян–Овоо	26	22	14	9	84.6	63.6	64.3
Уулбаяны Дэлгэр	9	6	5	3	66.7	83.3	60.0
Эрдэнэцагааны Жаргалант	26	25	23	22	96.2	92.0	95.7

**Өрх толгойлсон эх.** Сүүлийн 4 жилд аймгийн хэмжээгээр өрх толгойлсон эхчүүдийн тоо өссөн байна. 2010–2013 оны жилийн дундаж өсөлт 6.84 хувь байснаас 2013 оны эцсийн байдлаар 2206 болж нэмэгдсэний 64.7 хувь нь 3 хүртэл өрхийн гишүүдтэй, 29.1 хувь нь 3–5 гишүүдтэй, 6.1 хувь нь 6 ба түүнээс дээш гишүүдтэй байна.

## ХҮСНЭГТ 2.4 ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭХЧҮҮДИЙН ТОО

Үзүүлэлт	2010	2011	2012	2013	2013/2012 %
Өрх толгойлсон эх	1845	2118	2216	2206	99.5
<b>Үүнээс:</b> 3 хүртэл гишүүдтэй	1135	1426	1483	1428	96.3
3–5 хүртэл гишүүдтэй	639	623	671	643	95.8
6 ба дээш гишүүдтэй	71	69	62	135	217.7
<b>Эзлэх хувь:</b> 3 хүртэл гишүүдтэй	61.5	67.3	66.9	64.7	
3–5 хүртэл гишүүдтэй	34.6	29.4	30.3	29.1	
6 ба дээш гишүүдтэй	3.8	3.3	2.8	6.1	

2010–2013 онуудад зарим суманд өрх толгойлсон эхийн тоо буурсан боловч ихэнх суманд өссөний дотор Онгон, Сүхбаатар, Баруун–Урт, Баяндэлгэр, Түмэнцогт, Эрдэнэцагаан сумдад бусдаас илүү буюу жилд дундажаар 6.49–43.10 хувь өссөн байна.

## ХҮСНЭГТ 2.5 ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭХИЙН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ, сумаар, 2010–2013 он

Сум	2000	2010	2012	2013	2013/2012 %
Халзан	54	50	61	40	65.6
Наран	37	36	43	33	76.7
Дарьганга	93	85	82	83	101.2
Уулбаян	99	107	113	89	78.8
Мөнххаан	196	210	225	192	85.3
Асгат	66	66	66	67	101.5
Түвшинширээ	137	111	108	142	131.5
Эрдэнэцагаан	182	221	271	208	76.8
Түмэнцогт	106	148	144	128	88.9
Баяндэлгэр	117	131	104	143	137.5
Баруун–Урт	643	792	805	813	101.0
Сүхбаатар	72	96	108	142	131.5
Онгон	43	65	86	126	146.5
АЙМГИЙН ДҮН	1845	2118	2216	2206	99.5

ХҮСНЭГТ 2.6 ӨРХ ТОЛГОЙЛСОН ЭХИЙН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ,  
хамгийн их бууралттай ба өсөлттэй 5 баг

Сум	2000	2010	2012	2013	2010–2013 оны жилийн дундаж өөрчлөлт, %
Баруун–Урт, 9–р баг	49	45	45	24	53.3
Эрдэнэцагаан, Хонгор	22	13	19	13	68.4
Түмэнцогт, Баян–Овоо	40	80	86	24	27.9
Асгат, Их–Уул	13	11	8	8	100.0
Наран, Тосонгийн гол	16	16	15	10	66.7
...	...	...	...	...	...
Онгон, Ихбулаг	8	8	14	26	185.7
Онгон, Хавирга	11	16	21	36	171.4
Онгон, Нүдэн	8	12	14	27	192.9
Баруун–Урт, 1–р баг	15	28	18	172	955.6
Түмэнцогт, Баянцогт	0	0	0	40	–

**Хөгжлийн бэрхшээлтэй иргэд.** Тус аймагт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо 2010–2013 онуудад жилд дундажаар 5.81 хувь өссөөр 2013 онд 2663 болсны дотор 13.8 хувь нь харааны бэрхшээлтэй, 24.9 хувь нь хөдөлгөөний, 2.2 хувь нь хавсарсан, 59.1 хувь нь бусад бэрхшээлтэй хүмүүс байна.

ХҮСНЭГТ 2.7 ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО

Үзүүлэлт	2010	2011	2012	2013	2013/2012 %
Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо	2248	2516	2599	2663	102.5
<b>Үүнээс:</b> Харааны бэрхшээлтэй	304	335	367	367	100.0
Хөдөлгөөний бэрхшээлтэй	562	646	700	663	94.7
Хавсарсан	108	387	154	59	38.3
Бусад	1274	1148	1378	1574	114.2
<b>Эзлэх хувь:</b> Харааны бэрхшээлтэй	13.5	13.3	14.1	13.8	-
Хөдөлгөөний бэрхшээлтэй	25.0	25.7	26.9	24.9	-
Хавсарсан	4.8	15.4	5.9	2.2	-
Бусад	56.7	45.6	53.0	59.1	-

ХҮСНЭГТ 2.8 ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар

Сум	2010	2011	2012	2013	2013/2012 %
Наран	73	90	89	65	73.0
Дарьганга	93	94	96	90	93.8
Түмэнцогт	116	111	121	115	95.0
Асгат	89	84	79	91	115.2
Түвшинширээ	139	153	146	143	97.9
Онгон	180	184	189	191	101.1
Баяндэлгэр	223	246	285	251	88.1
Мөнххаан	133	133	131	154	117.6
Эрдэнэцагаан	245	288	232	289	124.6
Баруун-Урт	765	904	917	909	99.1
Уулбаян	82	96	118	128	108.5
Халзан	54	80	89	99	111.2
Сүхбаатар	56	53	107	138	129.0

2010–2013 онуудад Наран, Дарьганга, Түмэнцогтоос бусад бүх суманд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо 2.2 хувиас 2.5 дахин өссөн байна. Мөн онуудад Түмэнцогт сумын Баян-Овоо, Баруун-Урт сумын 4-р баг зэрэг 14 багт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо 2.7 хувиас 2.1 дахин буурсан байна. Харин Түмэнцогт сумын Баянцогт, Сүхбаатар сумын Ланз зэрэг 53 багт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоо 0.1 хувиас 3.4 дахин өссөн байна.

*ХҮСНЭГТ 2.9 ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН ТОО  
ХАМГИЙН ИХ БУУРСАН, ӨССӨН БАГ*

Сум	Баг	2010	2011	2012	2013	2013/2012%
Түмэнцогт	3-р баг, Баян-Овоо	45	40	39	21	53.8
Баруун-Урт	4-р баг	160	136	109	106	97.2
Наран	3-р баг, Наранбулаг	25	30	29	19	65.5
Наран	2-р баг, Тосонгийн гол	26	31	28	20	71.4
Мөнххаан	2-р баг, Баян-Уул	37	17	20	29	145.0
...	...	...	...	...	...	...
Сүхбаатар	5-р баг, Шинэбулаг	6	3	10	15	150.0
Баруун-Урт	9-р баг	19	35	106	52	49.1
Уулбаян	4-р баг, Жавхлант	4	7	12	11	91.7
Уулбаян	5-р баг, Дэлгэр	8	16	22	22	100.0
Халзан	4-р баг, Хатавч	16	28	41	46	112.2
Сүхбаатар	4-р баг, Ланз	7	6	14	24	171.4
Түмэнцогт	4-р баг, Баянцогт	0	0	0	22	-

### 3. БОЛОВСРОЛ, СОЁЛ

Ерөнхий боловсрол болон дээд боловсролын мэдээллийг Боловсрол, шинжлэх ухааны яам, мэргэжлийн боловсролын мэдээллийг Хөдөлмөрийн яам нэгтгэн Үндэсний статистикийн хороонд ирүүлдэг.

<b>Боловсрол</b>	Өргөн утгаар нь мэдлэг, хандлага, ур чадвар олж авах, зан чанарын болон төлөвшлийн хувьд нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн, үнэлэгдсэн байр суурьтай болох насан туршийн үйл ажиллагаа гэж тодорхойлж болно. Хувь хүний түвшинд буюу явцуу утгаар авч үзвэл боловсрол нь хүний өөрийгөө боловсруулж хөгжүүлэхийн тулд ухамсартайгаар хийж байгаа танин мэдэх үйл ажиллагаа, түүний үр дүн гэж тодорхойлж болно. Нийгмийн түвшинд боловсролыг иргэдийн сурч боловсрох, хөгжих эрхээ эдлэхэд нь төр, нийгмийн зүгээс дэмжлэг үзүүлж байгаа үйлчилгээ, түүний үр дүн гэж тодорхойлж болно.
<b>Боловсролын түвшин</b>	Ямар нэг шатны сургуулийг эх орондоо болон гадаадад дүүргэсэн хүний эзэмшсэн боловсролын хамгийн дээд түвшнээр тодорхойлно.
<b>Багш</b>	Танхимын сургалт, зайны сургалт гэдгээс үл хамааран сурагчид, оюутнуудын эрдэм мэдлэг олж авах үйл явцыг чиглүүлж, сургах, зааварлах эрх бүхий ажлын байранд бүтэн болон хагас цагаар ажиллаж байгаа хүнийг хэлнэ.
<b>Суралцагч</b>	Бүх шатны сургуульд хамрагдан суралцаж байгаа хүмүүсийг хэлнэ.
<b>Сурагч–багшийн харьцаа</b>	Тухайн хичээлийн жилд бүх шатны сургуулийн нэг багшид ногдож байгаа суралцагчийн дундаж тоо юм.
<b>Сургууль завсардалт</b>	Сурагч/оюутан тухайн хичээлийн жилд тухайн шатны сургуулийг төгсөлгүй сургуулиас бүрмөсөн гарсныг болон сургуулийн насны хүүхдүүд сургуульд огт оролгүй завсардсан тохиолдлуудыг хэлнэ.
<b>Сургууль төгсөгч</b>	Тухайн хичээлийн жилд тухайн түвшний боловсролын хөтөлбөрийг бүрэн, амжилттай дүүргэсэн сурагч/оюутныг хэлнэ.
<b>Хамран сургалтын бохир жин</b>	Нас харгалзалгүйгээр боловсролын тухайн түвшинд суралцагчдын тоог энэ түвшний боловсрол эзэмших насны нийт хүүхдийн тоонд харьцуулж, хувиар илэрхийлнэ.
Энэ бүлгийн боловсролын салбарын хэсэгт Сүхбаатар аймгийн бүх шатны боловсролын зарим үзүүлэлтийг сумын түвшинд бэлтгэн оруулав.	
<b>Соёл, урлагийн салбар</b>	Статистикийн мэдээллийг аймгуудын Соёл, спорт, аялал жуулчлалын газар, Нийслэлийн соёл, урлагийн газар цуглуулан боловсруулж, Соёл, спорт, аялал жуулчлалын яам нэгтгэн Үндэсний статистикийн хороонд ирүүлдэг.
Соёлын хэсэгт номын сан, номын сангийн суудал, номын фонд, номын сангаар үйлчлүүлэгчэд, соёлын төв, зохион байгуулсан арга хэмжээ, соёлын төвийн суудлын тоог сумын түвшинд бэлтгэн оруулав.	

**Боловсрол.** Сүхбаатар аймгийн боловсролын бүх шатны сургалтын байгууллагын тоо 2013–2014 оны хичээлийн жилийн эхэнд 39 байна. Боловсролын бүх шатны сургалтын байгууллагад суралцагчдын тоо 2013–2014 оны хичээлийн жилийн эхэнд 14491 болсон


байна. Боловсролын бүх шатны сургалтын байгууллагыг төгсөгчдийн тоо 2012–2013 оны хичээлийн жилд 1963 болж, өмнөх оныхоос 17.3 хувь буюу 410–аар буурсан байна. Харин боловсролын бүх шатны сургалтын байгууллагын үндсэн багшийн тоо 2013–2014 оны хичээлийн жилийн эхэнд 685 болж, өмнөх оныхоос 2.7 хувь буюу 18–аар нэмэгдсэн байна.

### ХҮСНЭГТ 3.1 АЙМГИЙН БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ

Үзүүлэлт	2010–2011	2011–2012	2012–2013	2013–2014	2013–2014 / 2012–2013, %
Сургалтын байгууллагын тоо, бүгд	37	37	38	39	102.6
<b>Үүнээс:</b> Сургуулийн өмнөх	20	20	21	21	100.0
Ерөнхий боловсролын	15	15	15	17	113.3
Техникийн болон мэргэжлийн	2	2	2	1	50.0
Суралцагчдын тоо, бүгд	14265	14292	14473	14491	101.5
<b>Үүнээс:</b> Сургуулийн өмнөх	3030	3225	3808	4267	112.1
Ерөнхий боловсролын	10374	10282	9964	9811	98.5
Техникийн болон мэргэжлийн	861	785	701	413	87.4
Төгсөгчдийн тоо, бүгд	1786	2373	1963	–	–
<b>Үүнээс:</b> Ерөнхий боловсролын	1529	2129	1744	–	–
Техникийн болон мэргэжлийн	257	244	219	–	–
Үндсэн багшийн тоо, бүгд	645	662	667	685	102.7
<b>Үүнээс:</b> Сургуулийн өмнөх	102	109	126	141	111.9
Ерөнхий боловсролын	519	521	510	516	101.2
Техникийн болон мэргэжлийн	24	32	31	17	90.3

Боловсролын салбарын сумаарх дэлгэрэнгүй мэдээлэл хавсралт 3.1–д

### СУРАГ 3.1 СУРАЛЦАГЧИД БА ҮНДСЭН БАГШ



Хамгийн олон буюу 5698 суралцагчтай сум бол Баруун–Урт, үүнээс ерөнхий боловсролын сургуульд 3899 суралцагчтай, Эрдэнэцагаан сум 1683 суралцагчтай, үүнээс ерөнхий боловсролын сургуульд 1228 сураглцагчтай, Мөнхаан сум 1156 суралцагчтай, үүнээс ерөнхий боловсролын сургуульд 856 сураглцагчтай байна. Цөөн суралцагчтай сумдад Асгат, Халзан, Наран сумд орж байна.

Тус аймагт техникийн болон мэргэжлийн нэг сургууль байгаа нь Баруун–Урт суманд буй Сүхбаатарын Мэргэжлийн сургалт–үйлдвэрлэлийн төв юм. Энэ сургуульд суралцагчдын тоо 413 байна.

*ХҮСНЭГТ 3.2 2013–2014 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН БОЛОВСРОЛЫН  
БАЙГУУЛЛАГА, СУРАЛЦАГЧДЫН ТОО, СУМААР*

Сум	Боловсролын байгууллагын тоо, бүгд	Нийт суралцагчдын тоо	Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын тоо	Суралцагчдын тоо	Ерөнхий боловсролын сургуулийн тоо	Суралцагчдын тоо	Техникийн болон мэргэжлийн сургалтын байгууллагын тоо	Суралцагчдын тоо
Баруун–Урт	14	5698	8	1386	4	3899	1	413
Асгат	2	272	1	112	1	160	–	–
Баяндэлгэр	2	1029	1	353	1	676	–	–
Дарьганга	2	645	1	214	1	431	–	–
Мөнхаан	3	1156	1	300	2	856	–	–
Наран	2	341	1	141	1	200	–	–
Онгон	2	935	1	270	1	665	–	–
Сүхбаатар	2	594	1	245	1	349	–	–
Түвшинширээ	2	697	1	250	1	447	–	–
Түмэнцогт	2	633	1	192	1	441	–	–
Уулбаян	2	517	1	210	1	307	–	–
Халзан	2	291	1	139	1	152	–	–
Эрдэнэцагаан	3	1683	2	455	1	1228	–	–


Сургуулийн өмнөх насны байгууллагын үндсэн багшийн ачаалал өндөртэй сумдын тоонд Наран, Онгон, Сүхбаатар сум орж байна. Ялангуяа Наран суманд 1 үндсэн багшид ногдох суралцагчийн тоо 47 байгаа нь мэргэжлийн багш дутагдалтай байгааг харуулж байна.

Харин Түмэнцогт, Баруун–Урт, Мөнхаан, Халзан, Асгат сумдад сургуулийн өмнөх насны байгууллагын багшийн ачаалал харьцангуй бага, 24–28 суралцагч ногдож байна.


*ХҮСНЭГТ 3.3 2013–2014 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛИЙН НИЙТ ҮНДСЭН БАГШИЙН  
ТОО, НЭГ БАГШИЙН АЧААЛАЛ*

Сум	Үндсэн багшийн тоо, бүгд	Үүнээс сургуулийн өмнөх боловсролын байгууллагын багш	Нэг үндсэн багшид ногдох суралцагчдын тоо	Ерөнхий боловсролын сургуулийн багш	Нэг үндсэн багшид ногдох суралцагчдын тоо	Мэргэжлийн сургалтын байгууллагын багш	Нэг үндсэн багшид ногдох суралцагчдын тоо
АЙМГИЙН ДҮН	685	141	30	516	19	17	24
Баруун-Урт	265	54	26	183	21	17	24
Асгат	18	4	28	14	11	-	-
Баяндэлгэр	51	9	39	42	16	-	-
Дарьганга	31	7	31	24	18	-	-
Мөнххаан	50	11	27	39	22	-	-
Наран	18	3	47	15	13	-	-
Онгон	39	6	45	33	20	-	-
Сүхбаатар	29	6	41	23	15	-	-
Түвшинширээ	32	7	36	25	18	-	-
Түмэнцогт	36	8	24	28	16	-	-
Уулбаян	29	7	30	22	14	-	-
Халзан	20	5	28	15	10	-	-
Эрдэнэцагаан	67	14	33	53	23	-	-

*ЗУРАГ 3.2 СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН  
БАГШИЙН АЧААЛАЛ, нэг үндсэн багшид ногдох хүүхдийн тоо, 2013*



**ЗУРАГ 3.3 ЕБС-ИЙН ҮНДСЭН БАГШИЙН АЧААЛАЛ**  
нэг үндсэн багшид ногдох суралцагчийн тоо, 2013



Сүхбаатар аймгийн боловсролын бүх шатны сургалтын байгууллагын тоо 2013–2014 оны хичээлийн жилийн эхэнд 39 байна. Боловсролын бүх шатны сургалтын байгууллагад суралцагчдын тоо 2013–2014 оны хичээлийн жилийн эхэнд 14491 болсон байна. Боловсролын бүх шатны сургалтын байгууллагыг төгсөгчдийн тоо 2012–2013 оны хичээлийн жилд 1963 болж, өмнөх оныхоос 17.3 хувь буюу 410-аар буурсан байна. Харин боловсролын бүх шатны сургалтын байгууллагын үндсэн багшийн тоо 2013–2014 оны хичээлийн жилийн эхэнд 685 болж, өмнөх оныхоос 2.7 хувь буюу 18-аар нэмэгдсэн байна.

**Соёл.** Аймгийн хэмжээнд 2013 оны байдлаар 2490 суудал бүхий 12 соёлын төв ажиллаж байна. Мэргэжлийн урлагийн байгууллагын тоглолт 46 удаа болж, 23.1 мянган үзэгчдэд үйлчилсэн байна. Мөн 4.6 мянган хүн музей үзсэн байна.

**ХҮСНЭГТ 3.4 АЙМГИЙН СОЁЛЫН БАЙГУУЛЛАГЫН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ**

Үзүүлэлт	2010	2011	2012	2013	2013/2012%
Соёлын төвийн тоо	12	12	12	12	100.0
Соёлын төвийн суудлын тоо	2400	2530	2620	2490	95.0
Мэргэжлийн урлагийн байгууллагын тоглолт	86	17	74	46	62.2
Мэргэжлийн урлагийн байгууллагын үзэгчдийн тоо, мянга	27.0	22.9	58.6	23.1	39.4
Музейн үзмэр	2184	2206	2391	2751	115.1
Музейн үзэгчдийн тоо, мянга	2.2	4.5	4.3	4.6	107.0
Номын сангийн тоо	13	13	13	13	100.0
Номын сангийн суудлын тоо	330	336	347	358	103.2
Байнгын уншигчдын тоо	5419	8819	8737	8795	100.7

Номын сангийн тоо 2010–2013 онд өөрчлөгдөөгүй 13 хэвээр, суудлын тоо 358, байнгын уншигчдын тоо өмнөх жилийнхээс 0.7 хувиар нэмэгджээ.

## 4. ЭРҮҮЛ МЭНД

Эрүүл мэндийн статистикийн мэдээллийг Эрүүл мэндийн яам (ЭМЯ)–ны харьяа байгууллага Эрүүл мэндийн хөгжлийн төв (ЭМХТ) нэгтгэн гаргаж, сар бүрийн 6–нд, мөн жилийн мэдээг дараа оны 3–р сарын 10–нд Үндэсний статистикийн хороонд ирүүлдэг.

Эрүүл мэндийн статистикт төрөлт, нас баралт, эх, нялхсын эндэгдэл, халдварт өвчин, эмч, өвчлөгчдийн тоо зэрэг үндсэн үзүүлэлтүүдийг авч үздэг.

<b>Эрүүл мэнд</b>	Хүн өвчин, эмгэггүй, бие бялдар, оюун санаа, нийгмийн амьдралын хувьд сайн сайхан байхыг хэлнэ.
<b>Эрүүл мэндийн байгууллага</b>	Хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх зорилго, үндсэн чиг үүрэг бүхий хуулийн этгээдийг хэлнэ.
<b>Эрүүл мэндийн ажилтан</b>	Эмнэлгийн мэргэжилтэн болон эрүүл мэндийн байгууллагад ажиллаж байгаа бусад ажилтныг нийтэд нь ойлгоно.
<b>Эмнэлгийн мэргэжилтэн</b>	Хүний их эмч, бага эмч, нүүр амны их эмч, сувилагч, эм зүйч, эх баригч, эм найруулагч, нийгмийн эрүүл мэндийн болон анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль, коллеж төгссөн эмнэлгийн бусад ажилтныг хэлнэ.
<b>Эмч</b>	анагаах ухааны чиглэлээр эх орондоо болон гадаадад дээд боловсрол эзэмшсэн, хүн эмчлэх эрхтэй хүнийг болон тухайн мэргэжлийг хэлнэ.
<b>Сувилагч</b>	Өвчтөнийг асарч сувилах, эм, тариаг эмчийн заасан цагт хийх үүрэг хүлээсэн эмнэлгийн дунд мэргэжилтэн юм.
<b>Амьд төрөлт</b>	Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байвал хүй эсвэл эхэсийг нь салгасан эсэхийг нь харгалзахгүйгээр амьд төрөлтөд тооцно.
<b>Эндсэн эх</b>	Жирэмсний хугацаанд болон төрөх үедээ эсвэл төрснөөс хойш 42 хоногийн дотор жирэмслэлтийн байрлал, үргэлжилсэн хугацаанаас үл хамааран жирэмслэлт, төрөлт болон түүнийг удирдахтай холбоо бүхий шалтгаанаар эндсэн эхийг хамааруулна.

Энэ бүлгийн эрүүл мэндийн хэсэгт эрүүл мэндийн байгууллага, төрөлт, нас баралт, өвчлөлийн мэдээг сумын түвшнээр бэлтгэн орууллаа.

**Эрүүл мэнд.** Тус аймагт 2013 онд 55 эрүүл мэндийн байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа нь 2010 оныхоос 34.1 хувь буюу 11–ээр нэмэгдсэн байна. Энэ хугацаанд нийт ажиллагчдын тоо 2.3 хувиар өссөний дотор их эмчийн тоо 14.2 хувь, тусгай мэргэжлийн ажилтны тоо 0.3 хувь, түүний дотор сувилагчийн тоо 6.8 хувиар нэмэгдсэн байна. Мөн эм зүйчийн тоо 2013 онд 2010 оныхоос 4–өөр өсчээ.

Эмнэлгийн орны тоо 0.6 хувь буюу 2–оор нэмэгдсэн байна.

## ХҮСНЭГТ 4.1 АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ

Үзүүлэлт	2010	2011	2012	2013	2013/2012%
Байгууллагын тоо	41	43	45	55	122.2
Их эмч	106	112	115	121	105.2
Эм зүйч	6	7	9	10	111.1
Тусгай мэргэжлийн мэргэжилтэн	335	330	329	336	102.1
Үүнээс: сувилагч	161	157	166	172	103.6
Бусад ажилтан	259	260	257	255	99.2
Эмнэлгийн орны тоо	317	317	317	319	100.6
Стационарт эмчлэгдсэн хүний тоо	12.7	12.6	12.3	12.2	99.2

Аймгийн дундажаар нэг их эмчид 466 хүн, нэг сувилагчид 328 хүн ногдож байхад хот, хөдөөд энэ үзүүлэлт харилцан адилгүй, ялангуяа сумдад эмч, сувилагч нарын ачаалал өндөр байна. Тухайлбал, Уулбаян суманд нэг их эмчид 2772 хүн, Түмэнцогт суманд 2342 хүн, Баяндэлгэр суманд нэг сувилагчид 1149, Эрдэнэцагаан суманд 1088 хүн ногдож байгаа нь нэн өндөр байна.

## ХҮСНЭГТ 4.2 СУМДЫН ИХ ЭМЧ, СУВИЛАГЧДЫН ТОО, АЧААЛАЛ, 2013

Сум	Их эмч	Нэг их эмчид ногдох хүний тоо	Сувилагчийн тоо	Нэг сувилагчид ногдох хүний тоо	Эмнэлгийн хүний тоо	Стационарт эмчлэгдсэн хүний тоо
Бүгд	121	466	172	328	319	12199
Баруун-Урт	89	205	107	170	183	7828
Асгат	2	867	5	347	8	255
Баяндэлгэр	3	1532	4	1149	14	451
Дарьганга	2	1426	5	570	10	437
Мөнххаан	3	1432	6	716	14	458
Наран	2	769	5	307	8	214
Онгон	6	608	7	521	17	551
Сүхбаатар	2	1573	5	629	10	436
Түвшинширээ	2	1537	7	439	10	316
Түмэнцогт	1	2342	5	468	10	323
Уулбаян	1	2772	5	554	10	332
Халзан	2	798	5	319	8	211
Эрдэнэцагаан	6	1088	6	1088	17	387

Аймгийн хэмжээнд амьд төрсөн хүүхдийн тоо 2010–2013 онуудад жилд дундажаар 1.8 хувь өссөн байна. Үүний зэрэгцээ 1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 2010 оныхоос 6–аар буурсан байна. Харин 1–5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл тогтворгүй байна.

Сүүлийн 4 жилд 1–5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл Асгат, Дарьганга, Наран, Сүхбаатар, Уулбаян, Халзан сумдад гараагүй нь нэн сайшаалтай байна.

### ХҮСНЭГТ 4.3 АМЬД ТӨРСӨН ХҮҮХЭД БА НЯЛХСЫН ЭНДЭГДЭЛ


Үзүүлэлт	2010	2011	2012	2013	2013/2012 %
Амьд төрсөн хүүхдийн тоо	1160	1297	1259	1224	97.2
Нэг хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	25	24	28	19	67.9
1–5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	5	8	5	7	140.0

Сүүлийн 4 жилийн байдлаар өвчний улмаас нас барсан хүний тоо буурахгүй байна. 2013 онд зүрх судасны тогтолцооны өвчний улмаас нас барсан хүний тоо 2010 онтой харьцуулахад 8.8 хувиар өсчээ. Дөрвөн жилийн дүнгээр нас баралтыг шалтгаанаар авч үзвэл зүрх судасны тогтолцооны өвчин 29.7 хувь, хавдар 28.1 хувийг эзэлж байгаа нь зонхилох шалтгаан болж байна.

### ХҮСНЭГТ 4.4 НАС БАРСАН ХҮН, зонхилох өвчний ангиллаар

Үзүүлэлт	2010	2011	2012	2013	2013/2012 %
Зүрх судасны тогтолцооны өвчин	102	108	85	111	130.6
Гэмтэл, хордлого ба гадны шалтгаант бусад тодорхой эмгэг	40	40	43	35	81.4
Хоол боловсруулах тогтолцооны өвчин	32	37	35	32	91.4
Амьсгалын тогтолцооны өвчин	16	13	15	10	66.7
Хавдар	95	103	86	99	115.1
Бусад	49	61	63	55	87.3
Дүн	334	362	327	342	104.6

ЗУРАГ 4.1 НАС БАРСАН ШАЛТГААН, зонхилох өвчний ангиллаар, хувиар, 2010–2013 он




Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо тогтвортой буурахгүй байна. 2010–2013 онуудад гахайн хавдар, салхин цэцэг өвчний гаралт нэмэгдсэнээс халдварт өвчнөөр өвчлөгчдийн нийт тоо 37.3 хувиар өсчээ.

2010 оноос хойш тогтмол өсөн нэмэгдэж буй халдварт өвчинд гахайн хавдар, салхинцэцэг орж байгаа ба 2010–2013 онуудад нийт халдварт өвчнөөр өвчлөгчдийн 30.1 хувийг гахайн хавдраар, 38.7 хувийг вирүст гепатитаар өвчлөгчид эзэлж буй нь хамгийн өндөр байна. Харин 2013 онд улаанууд, сальмонеллозоор өвчлөгчгүй, бруцеллёзоор өвчлөгчдийн тоо 7 болж, 2010 оныхоос 10 дахин буурчээ.

## ХҮСНЭГТ 4.5 ХАЛДВАРТ ӨВЧНӨӨР ӨВЧЛӨГЧИД, өвчний төрлөөр

Үзүүлэлт	2010	2011	2012	2013	2013/2012 %
Вирусст гепатит	160	160	112	44	39.3
Улаанууд	0	0	0	0	-
Гахайн хавдар	3	0	136	231	169.9
Менингоккт халдвар	1	0	1	1	100.0
Салхинцэцэг	30	19	30	104	346.7
Сальмонеллэз	3	0	5	0	0.0
Цусан суулга	18	2	10	10	100.0
Бруцеллэз	67	26	21	7	33.3
Гар, хөл, амны өвчин	10	12	1	3	300.0
Бусад	0	2	0	1	-
Дүн	292	221	316	401	126.9

ЗУРАГ 4.2 ХАЛДВАРТ ӨВЧНИЙ БҮТЭЦ, хувиар, 2010–2013 оны дүнгээр



## 5. НИЙГМИЙН ДААТГАЛ

Иргэн, төр, аж ахуйн нэгж байгууллагаас зохих журмын дагуу шимтгэл төлж нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, даатгуулагч өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, өвчлөх, ажилгүй болоход өөрт нь, тэрчлэн даатгуулагч нас барахад түүний асрамжинд байсан хүмүүст хууль тогтоомжинд заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх агуулга бүхий нийгэм, эдийн засгийн арга хэмжээ юм.

Энэ хэсэгт нийгмийн даатгалд даатгуулагчид, олгосон тэтгэврийн хэмжээ, тэтгэвэр авсан хүний тоог аймгийн түвшинээр бэлтгэн орууллаа.

Аймгийн хэмжээнд нийгмийн даатгалд даатгуулагчдын тоо 2013 онд 12.3 мянга болж, өмнөх оныхоос 7.2 хувь буюу 829 хүнээр өсчээ. Нийт тэтгэвэр авагчдын тоо 6.4 мянга байгаа нь өмнөх оныхоос 160 хүнээр нэмэгдсэн байна. Харин олгосон тэтгэврийн хэмжээ өмнөх оныхоос 12.7 хувь буюу 1.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

## ХҮСНЭГТ 5.1 АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮЗҮҮЛЭЛТ

Үзүүлэлт	2010	2011	2012	2013	2013/2012 %
Нийгмийн даатгалд даатгуулагчдын тоо	7108	8526	11471	12300	107.2
Нийт тэтгэвэр авагчдын тоо	6249	6062	6200	6360	102.6
Олгосон тэтгэврийн хэмжээ, сая төгрөг	6536.5	7848.7	12789.1	14418.2	112.7

## 6. ГЭМТ ХЭРЭГ, ШҮҮХ

### Гэмт хэрэг

Монгол Улсын “Эрүүгийн хууль”-д эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэдэг. Гэмт хэргийн статистикийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж 4 ангилдаг ба Монгол улсын Эрүүгийн хуульд заасан төрлөөр авч үздэг.

Гэмт хэргийн тоог Монгол Улсын Эрүүгийн хуульд заасны дагуу гэмт хэргийн төрлөөр нэгтгэн гаргаж байна. Тухайлбал:


- Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг;
- Хүүхэд, гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг;
- Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг;
- Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг;
- Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг;
- Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг;
- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг;
- Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг;
- Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг
- Бусад гэмт хэрэг.

Гэмт хэрэг үйлдэж гэм буруутай нь шүүхээр тогтоогдож, ял шийтгэл эдэлж буй болон ял шийтгэлгүйд тооцох хугацаа нь дуусаагүй этгээдийг ял шийтгэгдсэн хүнээртооцно. Энэ бүлэгт Сүхбаатар аймагт бүртгэгдсэн гэмт хэргийн тоог ангилал, төрлөөр, гэмт хэргийн улмаас хохирогчид, хохирлын хэмжээ, шүүхээр ял шийтгүүлсэн хүний тоог сумын түвшинд бэлтгэн орууллаа.

**Гэмт хэрэг, учирсан хохирол, хохирогчид.** Сүүлийн 4 жилийн байдлаар аймгийн түвшинд бүртгэгдсэн гэмт хэргийн тоо нэмэгдэж, жилд дундажаар 18 хувь өссөн байна. Нийт гэмт хэргийн 42.3 хувийг өмчлөх эрхийн эсрэг, үүний 36 хувийг зөвхөн малын хулгай эзэлж байна.

2013 онд гарсан нийт гэмт хэргийн 2.9 хувь нь онц хүнд, 6.1 хувь нь хүнд, 43.9 хувь нь хүндэвтэр хэргийн ангилалд хамаарч байна.

ЗУРАГ 6.1 ГЭМТ ХЭРГИЙН АНГИЛАЛ, 2010–2013 оны дүнгээр



## ХҮСНЭГТ 6.1 БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, төрлөөр

Үзүүлэлт	2010	2011	2012	2013	2013/2012%
Гэмт хэрэг, бүгд	190	183	207	312	150.7
Үүнээс: хөнгөн	82	87	74	147	198.6
хүндэвтэр	87	82	117	137	117.1
хүнд	17	11	14	19	135.7
онц хүнд	4	3	2	9	4.5 дахин
Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг	54	45	56	108	192.9
Үүнээс: хүнийг санаатай алах	4	3	2	7	350.0
бусдыг амиа хорлоход хүргэх	17	0	3	6	200.0
бусдын бие махбодид гэмтэл учруулах	33	42	48	95	197.9
Өмчлөх эрхийн эсрэг	94	83	93	132	141.9
Үүнээс: бусдын эд хөрөнгийг хулгайлах	84	73	79	106	134.2
үүнээс мал хулгайлах	29	27	38	48	126.3
бусдын эд хөрөнгийг дээрэмдэх	1	0	1	3	300.0
бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах	1	2	5	10	200.0
Нийгмийн аюулгүй байдлын эсрэг	16	26	26	26	100.0
Хүн амын эрүүл мэндийн эсрэг	0	1	0	1	-
Байгаль хамгаалах журмын эсрэг	2	0	1	3	300.0
ТХХАБАЖ-ын эсрэг	11	15	18	25	138.9

Гэмт хэргийн улмаас хохирогчдын дунд эмэгтэйчүүд, хүүхдийн эзлэх хувь 2013 оны байдлаар 31.4 хувь байна.

## ХҮСНЭГТ 6.2 ХОХИРОГЧ ИРГЭД


Үзүүлэлт	2010	2011	2012	2013	2013/2012%
Нийт хохирсон иргэн	160	146	198	315	25.33
Үүнээс: эмэгтэй	48	31	61	89	22.85
18 хүртэлх насны хүүхэд	6	3	6	10	18.56

Аймгийн хэмжээнд гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2013 онд 594.4 сая төгрөгт хүрч 2012 оноос 2 дахин өссөн байна. Хохирлын нөхөн төлүүлэлт сүүлийн 4 жилд дундажаар 41.5 хувиар өссөн боловч, 2013 оны байдлаар нөхөн төлөлтийн хувь хангалтгүй, 85.9 хувь байна.

## ХҮСНЭГТ 6.3 ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС УЧИРСАН ХОХИРОЛ БА НӨХӨН ТӨЛҮҮЛЭЛТ, сая төгрөг

Үзүүлэлт	2010	2011	2012	2013	2013/2012%
Учирсан нийт хохирол	198.5	89.4	293.4	594.4	202.6
Үүнээс: Төрийн өмчид	29.4	-	80.8	212.8	263.3
Орон нутгийн өмчид	19.2	-	2.6	10.0	385.0
Хувийн өмчид	176.4	89.4	210.1	371.6	177.0
Хохирол нөхөн төлүүлэлт	180.3	48.1	170.6	510.5	299.2

ЗУРАГ 6.2 ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС ӨМЧИД УЧИРСАН ХОХИРЛЫН БҮТЭЦ



ХҮСНЭГТ 6.4 БҮРТГЭГДСЭН НИЙТ ГЭМТ ХЭРЭГ, сумаар

Сум	2010	2011	2012	2013	2013/2012%
Дүн	190	183	207	312	150.7
Баруун-Урт	67	77	100	142	142.0
Асгат	7	2	2	7	350.0
Баяндэлгэр	7	5	7	5	71.4
Дарьганга	10	12	15	15	100.0
Мөнххаан	16	15	10	28	280.0
Наран	4	3	2	6	300.0
Онгон	6	2	5	6	120.0
Сүхбаатар	12	16	15	24	160.0
Түвшинширээ	2	1	6	10	166.7
Түмэнцогт	4	4	9	13	144.4
Уулбаян	3	9	7	9	128.6
Халзан	3	1	1	4	400.0
Эрдэнэцагаан	44	29	24	42	175.0



# ЭДИЙН ЗАСАГ

ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

БАНК, САНХҮҮ, ДААТГАЛ

ТӨРИЙН САНХҮҮ

ХӨДӨӨ АЖ АХУЙ

МАЛ АЖ АХУЙ

ГАЗАР ТАРИАЛАН

АВТО ТЭЭВЭР, ХАРИЛЦАА ХОЛБОО

БАРИЛГА, НИЙТИЙН АЖ АХУЙ

БАЙГАЛЬ ОРЧИН

ГАЗРЫН НЭГДМЭЛ САН

## 7. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН

Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)	ДНБ нь тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн нэг жилийн хугацаанд шинээр бий болгосон нийт нэмэгдэл өртгийн хэмжээ юм. ДНБ-ийг үйлдвэрлэлийн, эцсийн ашиглалтын, орлогын гэсэн 3 аргаар тооцно.
Үйлдвэрлэлийн арга	Нийт үйлдвэрлэлээс завсрын хэрэглээг хасаж нэмэгдэл өртгийн нийлбэр дүнгээр тооцохыг хэлнэ.
Эцсийн ашиглалтын арга	Эцсийн хэрэглээ, хуримтлал, цэвэр экспортын нийлбэрээр тодорхойлохыг хэлнэ.
Орлогын арга	Хөдөлмөрийн хөлс, үндсэн хөрөнгийн хэрэглээ буюу үндсэн хөрөнгийн элэгдэл, үйлдвэрлэл болон импортын цэвэр татвар, үйл ажиллагааны цэвэр ашиг, холимог орлого зэрэг орлогын элементийн нийлбэрээр тооцохыг орлогын арга гэж нэрлэнэ.

Аймаг, бүсийн ДНБ-ийг тооцоход харьяатын зарчим, нутаг дэвсгэрийн зарчим гэсэн 2 зарчмаас сонголт хийх болдог. Аймгийн ДНБ-ийг Үндэсний статистикийн хорооноос тооцож байна. Үндэсний тооцооны системд харьяатын зарчмыг баримталдаг. Харьяатын зарчмыг баримталж буй тохиолдолд аймгийн ДНБ-д тухайн аймгийн харьяат үйлдвэрлэгч нэгжийн эдийн засгийн үйл ажиллагааг хэмждэг юм. Аймаг, бүсийн ДНБ-ийг үйлдвэрлэлийн болон орлогын аргыг хослуулан ашигладаг.

**Дотоодын нийт бүтээгдэхүүн.** 2013 онд аймгийн нийт үйлдвэрлэл 427.0 тэрбум төгрөг, үүнээс завсрын хэрэглээ 154.9 тэрбум төгрөг, дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) 272.2 тэрбум төгрөгт хүрч өмнөх оныхоос 16.2 хувь буюу 38.0 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Нийт үйлдвэрлэлийн 36.3 хувийг завсрын хэрэглээ, 63.7 хувийг дотоодын нийт бүтээгдэхүүн эзэлж байна.

Аймгийн нэг хүнд дунджаар 5145.7 мянган төгрөгийн дотоодын нийт бүтээгдэхүүн ногдож байгаа нь зүүн бүсийн дунджаас 301.6 мянган төгрөгөөр дээгүүр байгаа бол, улсын дунджаас 1448.9 мянган төгрөгөөр доогуур байна.

### ХҮСНЭГТ 7.1 НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ, ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮН, оны үнээр, тэрбум төг

	2010	2011	2012	2013	2013/2012	
					хувь	(+,-)
Нийт үйлдвэрлэл	237.9	294.1	397.6	427.0	107.4	29.4
Завсрын хэрэглээ	94.7	115.6	163.4	154.9	94.8	-8.6
Дотоодын нийт бүтээгдэхүүн	143.2	178.6	234.2	272.2	116.2	38.0
Нийт үйлдвэрлэлд эзлэх хувь	100.0	100.0	100.0	100.0		
Завсрын хэрэглээ	39.8	39.3	41.1	36.3		
Дотоодын нийт бүтээгдэхүүн	60.2	60.7	58.9	63.7		
Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн, мян. төг						
Сүхбаатар аймаг	2777.6	3460.8	4485.6	5145.7	114.7	660.1
Зүүн бүс	2103.0	2905.0	3622.9	4844.0	133.7	1221.1
Улсын түвшинд	3562.6	4728.0	5876.8	6594.7	112.2	717.9

Улсын хэмжээний дотоодын нийт бүтээгдэхүүний 1.4 хувийг Сүхбаатар аймаг үйлдвэрлэж байна. Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүний 46.4 хувийг хөдөө аж ахуй, 36.8 хувийг аж үйлдвэр, барилга, 10.0 хувийг бусад үйлчилгээний салбар эзэлж байна.

*ХҮСНЭГТ 7.2 ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНД АЙМАГ БОЛОН  
САЛБАНУУДЫН ЭЗЛЭХ ХУВЬ*

	2010	2011	2012	2013
Дотоодын нийт бүтээгдэхүүнд аймгийн эзлэх хувь	1.5	1.4	1.4	1.4
Аймгийн ДНБ-д салбаруудын эзлэх хувь	100.0	100.0	100.0	100.0
Хөдөө аж ахуй, ой, ан агнуур	33.4	37.6	40.0	46.4
Аж үйлдвэр, барилга	52.4	47.5	44.2	36.8
Худалдаа, зочид буудал, зоогийн газар	1.2	1.3	1.3	1.8
Тээвэр, мэдээлэл, холбоо	0.6	0.7	0.6	0.6
Санхүү, бизнесийн бусад үйл ажиллагаа	4.1	4.3	4.3	4.3
Бусад үйлчилгээ	8.4	8.6	9.5	10.0

## 8. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

### Хөрөнгө оруулалт

Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хуримтлалыг шинээр бий болгох, түүний техникийн хүчин чадлыг нэмэгдүүлэн өргөтгөх, сайжруулахад зориулж, тайлант жилд зарцуулсан хөрөнгө, хайгуулын ажлын зардлыг ойлгоно. Хөрөнгө оруулалт нь гадаад, дотоод санхүүжилтийн эх үүсвэрээр бүрдэнэ.

Улс, орон нутгийн төсвөөр санхүүжсэн хөрөнгө оруулалт, гадаадын зээл, буцалтгүй тусламжийн шугамаар санхүүжсэн хөрөнгө оруулалтын мэдээллийг Сангийн яамнаас гаргаж Үндэсний статистикийн хороонд ирүүлэх бөгөөд гадаадын шууд хөрөнгө оруулалтын мэдээг Монголбанкны төлбөрийн тэнцлийн статистикийн мэдээллээс тооцон гаргаж байна. Харин орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт болон аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн өөрийн хөрөнгө оруулалтын мэдээллийг аймаг, нийслэлийн статистикийн хэлтэс, газар холбогдох нэгж, байгууллагуудаас авч нэгтгэн ҮСХ-нд ирүүлнэ.

Хөрөнгө оруулалтыг барилга угсралтын ажил, машин, тоног төхөөрөмж, геологи хайгуулын зардал болон бусад зардал (зураг төсөв, бусад биет бус хөрөнгө) гэсэн технологийн бүтцийн ангиллаар гаргаж байна.

Барилга угсралтын ажилд барилга байшин барих болон зам, гүүр, далан зэрэг инженерийн байгууламжийг барих хэлбэрээр үндсэн хөрөнгийг бий болгох, шинэчлэх, засварлах, өргөтгөхөд чиглэсэн үйл ажиллагааг хамруулна.

Машин, тоног төхөөрөмжид бүх төрлийн тээврийн хэрэгсэл, механик тоног төхөөрөмж, цахилгаан хэрэгсэл, тэдгээрийн сэлбэг, эд ангийг хамруулна.

Бусад зардалд зураг төсөв, программ хангамж, мэдээллийн сан, биет бус хөрөнгийн зардлыг хамруулна.

**Хөрөнгө оруулалт.** Сүхбаатар аймагт 2013 онд улсын төсвөөс 19.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн нь өмнөх оныхоос 4.0 хувь, орон нутгийн төсвөөс 6.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн нь өмнөх оныхоос 2.7 дахин нэмэгджээ.

ХҮСНЭГТ 8.1 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, сая төгрөг

Үзүүлэлт	2011	2012	2013	2013/2012*
Улсын төсвийн хөрөнгө оруулалт	9644.0	18497.8	19236.4	104.0
Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	4424.4	2272.3	6086.1	267.8
Үүнээс: Орон сууцны барилга	1074.4	151.0	1252.0	8 дахин
Бусад барилга, байгууламж, автозам	2551.8	1357.6	3444.2	253.7
Их засвар, өргөтгөл, шинэчлэл	475.4	147.9	792.9	5 дахин
Машин, тоног төхөөрөмж	263.5	577.8	597.0	103.3
Өсөж үрждэг хөрөнгө, мал, ургамал	5.2	-	-	-

## 9. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

### Хэрэглээний үнийн индекс

(ХҮИ) нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг илэрхийлэх үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна. Хэрэглээний үнийн индексийг төрөөс санхүү, мөнгө, зээлийн бодлогыг боловсруулах, инфляцийн түвшинг тодорхойлох, хүн амын цалин, тэтгэвэр, тэтгэмж, бусад орлогын хэмжээг индексжүүлэхэд тооцооны гол үзүүлэлт болгон ашигладаг.

ХҮИ-ийн тооцоонд хэрэглээний сагс, хэрэглээний жингэсэн хоёр үзүүлэлтийг ашиглана.

### Хэрэглээний сагс

Хэрэглээний сагс нь дундаж зарлагатай өрхийн хэрэглээг төлөөлөх чадвартай, хэрэглээний үнийн индекс тооцох зорилгоор бүрдүүлсэн хүн амын өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний нэр төрлийн жагсаалт юм. Сагсанд сонгогдсон бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийг тооцоход бараа, үйлчилгээний тоо хэмжээ, төрөл, чанар зэргийг тогтмолоор авч үздэг.

### Хэрэглээний бараа, үйлчилгээний жин

Хэрэглээний бараа, үйлчилгээний жин гэж өрхийн худалдаж авсан бараа, үзүүлсэн үйлчилгээний нийт зардалд тухайн бараа, үйлчилгээний зардлын эзлэх хувийг ойлгоно.

ҮСХ нь 1991 оноос Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын аргачлалаар ХҮИ-ийг тооцож эхэлсэн бөгөөд 1991 оноос хойш ХҮИ тооцдог хэрэглээний сагсны нэр төрөл, жин болон суурь үеийг 4 удаа шинэчилсэн.

ҮСХ нь хэрэглээний сагсны нэр төрлийг 2011 онд 329 болгон нэмэгдүүлж, (аймгуудад 214 нэр төрөл), 2010 оны өрхийн нийгэм эдийн засгийн судалгааны үр дүнгээр хэрэглээний зардлын жинг шинэчлэн 2010 оны 12 дугаар сарын суурь үетэй харьцуулснаар 2012 оны 1 дүгээр сараас хэрэглээний үнийн индексийг тооцон нийтэд мэдээлж байна. Хэрэглээний үнийн улсын индексийг хувийн зориулалттай хэрэглээний бараа, үйлчилгээний ангиллын үндсэн 12 бүлгийн түвшинд нэгтгэн тооцож байна.

ҮСХ нь хэрэглээний сагсны нэр төрлийг 2011 онд 329 болгон нэмэгдүүлж, (аймгуудад 214 нэр төрөл), 2010 оны өрхийн нийгэм эдийн засгийн судалгааны үр дүнгээр хэрэглээний зардлын жинг шинэчлэн 2010 оны 12 дугаар сарын суурь үетэй харьцуулснаар 2012 оны 1 дүгээр сараас хэрэглээний үнийн индексийг тооцон нийтэд мэдээлж байна. Хэрэглээний үнийн улсын индексийг хувийн зориулалттай хэрэглээний бараа, үйлчилгээний ангиллын үндсэн 12 бүлгийн түвшинд нэгтгэн тооцож байна.

Хэрэглээний үнийн бүсийн индексийг 2012 оноос дээрх ангиллын 12 бүлгийн түвшинд тооцож, нийтэд тархааж байна.

Хэрэглээний үнийн судалгааг 1997 оноос аймгийн төвүүдэд сар тутам явуулж, аймаг бүрийн үнийн индексийг тооцож байна.

Монгол улсын нийт 329 сумаас аймгийн хүн амын 70 хувь нь амьдарч буй сумдыг үнийн судалгаанд хамруулахаар зорилтот түүвэр хийсэн. Энэ түүврийн дагуу үнийн судалгаанд Дархан-Уул, Орхон, Говьсүмбэр аймгаас бусад 18 аймгийн нэр бүхий 112 сумдыг судалгаанд хамруулж нэгтгэн тооцож байна.

Сүхбаатар аймгийн Баяндэлгэр, Мөнххаан, Онгон, Эрдэнэцагаан сум хэрэглээний үнийн мэдээнд хамрагдаж, 142 нэр төрлийн хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ, тарифыг цуглуулж байна.

**Инфляци.** Сүхбаатар аймагт 2013 оны байдлаар инфляци 10.1 хувь байгаа нь улсын түвшнээс 2.4 пунктээр доогуур байв. Инфляцийн 2013 онд 10.1 хувийн өсөлтийн 2.9 нэгж буюу 28.2 хувь нь хувцас, бөс бараа, гутлын бүлгийн, 2.7 нэгж буюу 26.9 хувь нь хүнсний барааны бүлгийн, 1.2 нэгж буюу 12.0 хувь нь гэр ахуйн барааны бүлгийн үнийн өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

Улсын инфляцитай харьцуулж үзвэл хувцас, бөс бараа, гутлын барааны бүлгийн үнийн өсөлт Сүхбаатар аймагт илүү нөлөөлсөн харагдаж байна

*ХҮСНЭГТ 9.1 ИНФЛЯЦИЙН 2013 ОНЫ ӨСӨЛТӨД ҮЗҮҮЛСЭН  
БҮЛГҮҮДИЙН НӨЛӨӨЛӨЛ*


Бараа, үйлчилгээний бүлэг	Улс		Сүхбаатар	
	Пункт	Хувь	Пункт	Хувь
Ерөнхий индекс	12.5	100.0	10.1	100.0
01.Хүнсний бараа, согтууруулах бус ундаа	4.0	32.0	2.7	26.9
02.Согтууруулах ундаа, тамхи	0.5	4.3	0.5	5.2
03.Хувцас, бөс бараа, гутал	3.0	23.8	2.9	28.2
04.Орон сууц, ус, цахилгаан, түлш	1.0	7.8	0.3	3.4
05.Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	0.8	6.4	1.2	12.0
06.Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	0.4	3.4	0.4	3.9
07.Тээвэр	0.4	2.9	0.5	4.6
08.Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	0.0	-0.1	-0.1	-1.2
09.Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	0.0	0.1	0.1	0.7
10.Боловсролын үйлчилгээ	1.3	10.5	0.6	6.3
11.Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	0.5	3.9	0.3	2.6
12.Бусад бараа, үйлчилгээ	0.6	5.1	0.7	7.4

Өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн түвшингээс харахад Мөнххаан суманд бусдаас илүү өндөр үнэтэй байна.

*ХҮСНЭГТ 9.2 ӨРГӨН ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРИМ БАРАА,  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ДУНДАЖ ҮНЭ, сумаар*

Нэр төрөл	Баяндэлгэр	Мөнххаан	Онгон	Эрдэнэцагаан
Гурил, I зэрэг, кг	814	1077	1079	1066
Цагаан будаа, кг	1881	2019	1829	1476
Хонины мах, кг	7113	7000	6357	5000
Үхрийн мах, кг	8129	8000	6357	5000
Шингэн сүү, л	1195	1286	1205	1000
Өндөг, ш	371	395	374	376
Төмс, кг	724	990	943	886
Лууван, кг	1005	1395	1443	1414
Элсэн чихэр, кг	1738	1800	1767	1912
Цахилгаан, кВтц	85	103	96	110
Бензин, А-80, л	1630	1621	1660	1697
Дизелийн түлш, л	1900	1887	1920	1947

ЗУРАГ. 9.1 АЙМГИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН МЭДЭЭНД ХАМРАГДДАГ СУМД



## 10. БАНК, САНХҮҮ, ДААТГАЛ

Монгол банк арилжааны банкуудын тайлан тэнцлийн мэдээллийг нэгтгэн мөнгөний нийлүүлэлт, мөнгөний тойм, банкуудын нэгдсэн тайлан, олгосон зээлийн өрийн үлдэгдэл, хадгаламж, зээлийн хүү, гадаад валютын зах зээлийн ханшийн талаарх статистикийн мэдээг сар бүр бэлтгэдэг бөгөөд мөнгө, зээлийн бодлогын үр дүнгийн жилийн тайланг гаргадаг. Харин Санхүүгийн зохицуулах хороо нь ББСБ, ХЗХоршоо, даатгалын байгууллагуудын санхүүгийн тайланг улирал бүр авч мэдээг ҮСХ–нд ирүүлдэг.

<b>Хадгаламж</b>	Тухайн данс эзэмшигч хүүний орлого олох зорилгоор хугацаатай эсвэл хугацаа заахгүйгээр хадгаламжийн байгууллагад байршуулсан мөнгөн хадгаламжийг хэлнэ.
<b>Зээл</b>	Иргэд, байгууллагад олгосон зээлийн үлдэгдлийг хэлэх ба зээлийн чанар буюу хугацааны үзүүлэлтээр хэвийн, хугацаа хэтэрсэн, чанаргүй зээл гэж ангилна. Зээлийн өрийн үлдэгдлийг улсын байгууллага, хувийн хэвшил, иргэд, бусад санхүүгийн бус байгууллага, санхүүгийн бусад байгууллага гэсэн ангиллаар, нийт дүнгээр мэдээлнэ.
<b>Малын индексжүүлсэн даатгал (МИД)</b>	Индексст суурилсан даатгал нь байгалийн давагдашгүй хүчин зүйлээс учрах эрсдэлээс хамгаалах зорилготой, даатгалын нэгж тохиолдолд бус, тодорхой үзүүлэлтүүдэд үндэслэн хохирлын нөхөн төлбөрийг олгодог даатгалын хэлбэр юм.
<b>Банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)</b>	ББСБ нь зээл олгох, факторингийн үйлчилгээ, санхүүгийн түрээсийн үйлчилгээ, төлбөрийн баталгаа гаргах үйлчилгээ, төлбөр тооцооны хэрэгсэл гаргах үйлчилгээ, цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ, гадаад валютын арилжаа, итгэлцлийн үйлчилгээ, богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх, хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээллээр үйлчлэх зэрэг үйл ажиллагаа явуулдаг.
<b>Хоршоо</b>	Хоршоо гэж эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээгээ хангах зорилгоор хэд хэдэн этгээд сайн дураараа нэгдсэн, хамтын удирдлага, хяналт бүхий, дундын эд хөрөнгө дээр үндэслэн үйл ажиллагаа явуулахаар хамтран байгуулсан хуулийн этгээдийг хэлнэ.

Энэ бүлэгт Сүхбаатар аймгийн банкуудын хадгаламж, зээлийн үзүүлэлт, малын индексжүүлсэн даатгалын үзүүлэлтийг сумын түвшинд, ББСХ, ХЗХ–ын зарим үзүүлэлийг аймгийн түвшинд бэлтгэн орууллаа.

**Хадгаламж, зээл.** Тус аймгийн нийт хадгаламж 2010–2013 онд жилд дундажаар 42.8 хувь нэмэгдсээр, 2013 оны эцэст 33.2 тэрбум төгрөгт хүрсэн байна. Хадгаламж илүү хурдацтай өссөн сум бол Уулбаян, Наран, Халзан, Түвшинширээ, Онгон сумд байна. Иргэдийн хадгаламж өсөх нь амьжиргааны түвшний нэг үзүүлэлт юм.

Улсын түвшинд нэг өрхийн хадгаламжийн дундаж хэмжээ 5825.2 мянган төгрөг, аймгийн түвшинд 1998.3 мянган төгрөг байгаа бол энэ аймагт 2024.5 мянган төгрөг байна.

Тус аймгийн хувьд арилжааны банкуудын олгосон зээлийн өрийн үлдэгдэл 2013 онд 73.5 тэрбум төгрөг болж 2010–2013 онуудад жилд дундажаар 15.7 хувиар өссөн байна. Улсын хэмжээнд аймгийн түвшний нэг сумын дундаж зээлийн өрийн үлдэгдэл 6974.9 сая төгрөг байгаа бол Сүхбаатар аймгийн сумын дундаж 5700.0 сая төгрөг байна.

*ХҮСНЭГТ 10.1 ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, сая төгрөг*

Үзүүлэлтүүд	2010	2011	2012	2013	2013/2012
Нийт хадгаламж	11412.5	16790.5	25282.0	33228.4	131.2
Хугацаатай	3877.5	5830.0	7670.5	10492.0	136.4
Хугацаагүй	7535.0	10960.4	17611.5	22736.4	129.0
Зээлийн өрийн үлдэгдэл	19582.3	35131.7	46941.4	73479.3	156.7
Хадгаламж, зээлийн хоршоодын тоо	3	3	2	2	100.0
Хүүгийн орлого, сая төгрөг	35.7	41.3	40.3	45.3	112.4
Хүүгийн зарлага, сая төгрөг	12.6	14.3	15.0	19.6	130.7

Сумдын дотроос аймгийн төв–Баруун–Урт сумын хадгаламж хамгийн их, дараа нь Баяндэлгэр, Онгон, Эрдэнэцагаан, Дарьганга сум, хамгийн бага нь Халзан сум байна.

*ХҮСНЭГТ 10.2 ХАДГАЛАМЖ, сумаар, сая төгрөг*

Үзүүлэлтүүд	2010	2011	2012	2013	2013/2012%
Баруун–Урт	6024.7	8244.8	11511.3	16259.7	141.2
Асгат	337.8	585.6	848.0	962.9	113.5
Баяндэлгэр	941.9	1282.5	2126.5	2314.7	108.9
Дарьганга	693.7	1067.7	1437.1	1906.9	132.7
Мөнххаан	578.7	869.0	1439.6	1702.3	118.2
Наран	230.2	480.0	840.1	1070.3	127.4
Онгон	669.9	1070.0	1729.2	2142.8	123.9
Сүхбаатар	380.7	413.9	711.1	924.0	129.9
Түвшинширээ	206.4	413.7	628.1	834.0	132.8
Түмэнцогт	208.7	474.5	958.2	1288.0	134.4
Уулбаян	223.0	355.9	733.1	1110.0	151.4
Халзан	163.1	290.6	456.9	666.7	145.9
Эрдэнэцагаан	753.6	1242.3	1862.9	2046.1	109.8

**Малын даатгал.** Тус аймагт 2013 онд 635 малчин өрхийн 188.4 мянган толгой мал даатгалд хамрагджээ. Нийт малчин өрхийн 9.8 хувь, малын 7.6 хувь даатгалд хамрагдсан байна. Нийт сумдын дотор Түвшинширээ сум хамгийн их буюу нийт малын 14.8 хувь, Халзан 14.2 хувь, Мөнххаан 13.0 хувь, Түмэнцогт 12.3 хувийг даатгуулсан байхад Баруун–Урт сум хамгийн бага буюу 0.4 хувийг даатгуулсан байна.

*ХҮСНЭГТ 10.3 МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛД ХАМРАГДСАН МАЛЧИН ӨРХ, ДААТГУУЛСАН МАЛЫН ТОО*

Үзүүлэлтүүд	2010	2011	2012	2013	2013/2012%
Даатгуулсан өрхийн тоо	648	853	590	635	107.6
Нийт малчин өрхөд эзлэх хувь	9.4	12.5	9.0	9.8	108.7
Даатгуулсан малын тоо, мян.тол	119.1	167.1	149.1	188.4	126.3
Нийт малын дүнд эзлэх хувь	6.0	8.0	6.5	7.6	115.6

## ХҮСНЭГТ 10.4 МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛ, сумаар

Сум	Даатгуулсан өрхийн тоо				Даатгуулсан малын тоо, толгой			
	2010	2011	2012	2013	2010	2011	2012	2013
Бүгд	648	853	590	635	119053	167107	149145	188359
Баруун–Урт	18	9	8	9	2697	1088	1440	1001
Асгат	36	40	19	11	4471	7288	4369	4530
Баяндэлгэр	49	115	86	103	8085	16571	14721	19028
Дарьганга	33	27	8	29	7704	10518	4770	11471
Мөнххаан	59	66	72	92	10239	10616	18156	34711
Наран	35	60	37	33	3757	4597	1989	5872
Онгон	28	87	42	73	6007	26921	15352	26030
Сүхбаатар	29	17	1	26	3707	1901	174	4410
Түвшинширээ	73	133	147	99	26520	40025	50727	37622
Түмэнцогт	116	99	53	32	19336	13952	7232	8779
Уулбаян	49	60	31	33	7235	8716	8096	8537
Халзан	54	80	58	60	7080	14464	14684	16829
Эрдэнэцагаан	69	60	28	35	12215	10450	7435	9539

## 11. ТӨРИЙН САНХҮҮ

Монгол Улсын нэгдсэн төсөв нь улсын төсөв, орон нутгийн төсөв, Хүний хөгжлийн сангийн төсөв (2010 он хүртэл Монгол улсыг хөгжүүлэх сан гэсэн нэртэй байсан) болон нийгмийн даатгалын сангийн төсвөөс бүрдэнэ.

Улсын Их Хурлаас баталсан, Засгийн газар бүрдүүлэн, зарцуулах төсвийг улсын төсөв гэнэ. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын бүрдүүлэн, зарцуулах төсвийг орон нутгийн төсөв гэнэ. Орон нутгийн төсөв нь аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвөөс бүрдэнэ.

Монгол Улсын төсвийн жил тухайн оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхэлж 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болдог.

Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого, зарлагын мэдээг Сангийн яам нэгтгэн гаргаж байна.

### Төсвийн орлого

Төсвийн орлого нь тогтворжуулалтын сангийн болон тэнцвэржүүлсэн орлогоос бүрдэнэ. Тэнцвэржүүлсэн орлого нь урсгал орлого, хөрөнгийн орлого, тусламжийн орлогоос бүрдэнэ. Татварын болон татварын бус орлогоос урсгал орлого бүрдэнэ. Татварын орлогод орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэл, хураамж, өмчийн татвар, дотоодын бараа, үйлчилгээний татвар, гадаад худалдааны татварын орлого болон бусад татвар орно. Төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг, хүү, торгуулийн орлого, түрээсийн орлого, төсөвт газрын өөрийн орлого болон бусад орлогоос татварын бус орлогыг бүрдүүлдэг.

### Төсвийн зарлага

Төсвийн зарлагыг урсгал зардал, хөрөнгийн зардал, цэвэр зээл гэж ангилна. Урсгал зардалд бараа, үйлчилгээний зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, татаас ба шилжүүлэг багтана.

### Төсвийн тэнцвэржүүлсэн нийт ашиг

Төсвийн тэнцвэржүүлсэн нийт ашиг /алдагдал/ гэж нийт орлого, тусламжийн дүн нийт зарлага, цэвэр зээлийн дүнгээс их /бага/ байхыг хэлнэ. Урсгал тэнцлийг урсгал орлого ба урсгал зардлын зөрүүгээр тодорхойлно.


Энэхүү бүлэгт Сүхбаатар аймгийн төсвийн орлого, зарлагыг аймгийн түвшинд, эдийн засгийн ангиллаар бэлтгэж орууллаа.

**Төсвийн орлого, зарлага.** Сүхбаатар аймгийн төсвийн орлого, тусламжийн хэмжээ 2013 онд 44.5 тэрбум төгрөг болжээ. 2013 онд нийт орлого, тусламжийн дүнд тусламжийн орлого 36.2 тэрбум төгрөг буюу 81.3 хувь, урсгал орлого 8.1 тэрбум төгрөг буюу 18.2 хувь, хөрөнгийн орлого 0.3 тэрбум төгрөг буюу 0.6 хувийг эзэлж байна. Аймгийн төсвийн нийт орлого, тусламжийн дүн 2013 онд 2010 оныхоос 5.8 дахин нэмэгдсэн бөгөөд үүний дотор тусламжийн орлого эрс нэмэгдсэн байна. Аймгийн төсвийн нийт зарлага 2013 онд 44.4 тэрбум төгрөгт хүрчээ. Нийт зарлагын дүнд урсгал зардал 75.5 хувь, хөрөнгийн зардал 24.5 хувийг бүрдүүлж байна.


## ХҮСНЭГТ 11.1 АЙМГИЙН ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГО, ЗАРЛАГА, сая төг

Үзүүлэлтүүд	2010	2011	2012	2013	2013/2012%
Нийт орлого ба тусламжийн дүн	7684.8	7964.1	9893.6	44548.0	4.5 дахин
Урсгал орлого	7584.2	7181.8	9192.9	8090.2	88.0
Татварын орлого	6972.8	6631.7	8683.0	6020.5	69.3
Татварын бус орлого	611.4	550.1	509.9	2069.7	4 дахин
Хөрөнгийн орлого	100.6	782.3	139.7	256.5	183.6
Тусламжийн орлого	–	–	560.9	36201.3	64 дахин
Нийт зарлагын дүн	6581.8	7227.2	9703.9	44361.4	4.6 дахин
Урсгал зардлын дүн	6479.5	4280.3	5507.3	33514.5	6 дахин
Хөрөнгийн зардал	102.4	2946.9	4196.6	10846.8	258.5
Төсвийн тэнцэл	1103.0	736.9	189.7	186.6	–

ЗУРАГ 11.1 АЙМГИЙН ТӨСВИЙН ТЭНЦЭЛ, тэрбум төгрөг



ЗУРАГ 11.2 АЙМГИЙН ТӨСВИЙН НИЙТ ЗАРЛАГЫН БҮТЭЦ



- Цалин, урамшил 37.0%
- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлсөн шимтгэл 4.1%
- Бараа үйлчилгээний бусад зардал 21.1%
- Татаас ба урсгал шилжүүлэг 13.4%
- Дотоод хөрөнгө оруулалт 24.5%

## 12. ХӨДӨӨ АЖ АХУЙ

Хөдөө аж ахуйн нийт үйлдвэрлэлийн хэмжээг жилийн туршид мал, амьтдыг өсгөн үржүүлсэний болон ургамал, тариа, хүнсний ногоо тарьж ургуулсаны үр дүнд бий болсон хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний өртгийн нийлбэр дүнгээр тодорхойлно.

### Мал аж ахуй

Малын жил бүрийн тооллого, мөн хашаа худгийн болон бусад тооллого, судалгаа нь мал аж ахуйн салбарын мэдээллийн гол эх үүсвэр юм.

Мал тооллогыг зун, намрын улиралд ихэвчлэн 8, 9 дүгээр сард явуулж байснаа 1961 оноос мал, тэжээвэр амьтдыг жилийн эцэст 12 дугаар сард тоолдог болов. Энэ хугацаа нь мал аж ахуйн үйлдвэрлэлийн жилтэй тохирдог, малын орлого, зарлагын үзүүлэлт бүрэн гарч дууссан байдаг зэрэг давуу талтай.

Мал тооллогын дүн нь зөвхөн мал, гэрийн тэжээвэр амьтдын тоо толгойн өсөлт, бууралтыг харуулах төдийгүй сүргийн нөхөн үйлдвэрлэлийн үзүүлэлтийг тодорхойлж судлах, шинжлэх бололцоог олгодог.

Хөдөө аж ахуйн салбарын боловсон хүчин, ашиглаж буй машин, техник, хашаа, худгийн тооллогыг 1996 оноос хойш гурван жил тутамд явуулж байна.

Манай улсын хувьд мал аж ахуйн үйлдвэрлэгчид нь малчдын өрхийн аж ахуй билээ.

### Малтай өрх

Малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэйгээр өсгөн үржүүлдэг өрхийг хамруулна.

### Малчин өрх

Малчин өрх гэж жилийн 4 улирлын туршид малаа малладаг бөгөөд малын ашиг шим тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа өрхийг хэлнэ.

### Хээлтэгч мал

Хээлтэгч малд нас гүйцсэн эм малыг хамруулна.

### Төлийн бойжилтын хувь

Төлийн бойжилтын хувийг гаргахдаа бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулан 100-гаар үржүүлнэ.

### 100 эхээс бойжуулсан төл

100 эхээс бойжуулсан төлийг бойжуулсан төлийн тоог оны эхний хээлтэгч малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлж тооцно.

### Зүй бусаар хорогдсон мал

Зүй бусаар хорогдсон малын тоонд халдвартай, халдваргүй өвчин, зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг гэнэтийн аюул болон араатан, жигүүртэнд идүүлэх, худаг, хавцалд унах зэрэг хариулга, маллагаатай холбоотой шалтгаанаар хорогдсон малыг хамруулна.

### Хүнсэнд хэрэглэсэн мал

Хүнсэнд хэрэглэсэн малын тоог тооцохдоо оны эхний малын тоон дээр бойжуулсан төлийг нэмж, том малын зүй бус хорогдол, оны эцсийн малын тоог хасна.

Энэ бүлгийн мал аж ахуйн хэсэгт малчин өрх, малчид, тэдгээрийн соёл ахуйн зарим үзүүлэлтүүд, мал, хээлтэгч мал, бойжуулсан төл, тэжээвэр амьтад, хашаа, худаг, бэлчээрийн даац, тэжээлийн хүрэлцээ гэсэн мэдээллийг сум, багийн түвшинд бэлтгэж орууллаа. 1990 оноос хойших малын тоог сумын түвшинд бэлтгэж оруулав.

### МАЛ АЖ АХУЙ, МАЛЧИН ӨРХ


**Малчин өрх, малчид.** Аймгийн хамжээгээр малчин өрхийн тоо 2010–2013 онуудад жилд дундажаар 2.2 хувиар буурсаар 2013 онд 6466 малчин өрхтэй байна. Малчдын тоо ч мөн жилд дундажаар 3.2 хувиар буурч, одоо 13742 болсон байна.

## ХҮСНЭГТ 12.1 МАЛЧИН ӨРХ, МАЛЧДЫН ТОО

Үзүүлэлтүүд	1990	2000	2010	2011	2012	2013	2013/2012%
Малчин өрхийн тоо	2735	7324	6909	6834	6530	6466	99.0
Малчдын тоо	5821	17796	15142	14921	13988	13742	98.2

Малчин өрхийн тооны сумаарх мэдээлэл хавсралт 12.1.1-д  
Малчин өрхийн тооны багаарх мэдээлэл хавсралт 12.2.2-т

ЗУРАГ 12.1 МАЛЧИН ӨРХ, МАЛЧДЫН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ



**Малчдын соёл ахуйн зарим үзүүлэлт.** 2013 оны мал тооллогоор аймгийн малчин өрхийн 88.0 хувь нь цахилгаан үүсгүүртэй, 78.1 хувь телевизортой, 39.1 хувь автомашинтай, 49.3 хувь мотоциклтой, 0.6 хувь нь трактортой гэсэн дүн гарчээ. Сүхбаатар аймгийн малчин өрхүүдийн цахилгаан, телевизор, автомашин, мотоциклийн хангамж улсын дунджаас өндөр, гагцхүү трактороор хангагдсан байдал л доогуур гарсан байна.

ХҮСНЭГТ 12.2 МАЛЧИН ӨРХИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ,  
нийт өрхөд харьцуулсан хувь

Үзүүлэлтүүд	2010	2011	2012	2013	2013/2012%
<b>Сүхбаатар:</b> Цахилгаан үүсгүүртэй	77.7	89.0	77.0	92.8	120.5
Телевизортой	63.9	80.4	66.8	78.1	117.0
Машинтай	24.6	29.2	30.8	39.1	126.9
Мотоциклтой	39.0	49.4	46.2	49.3	106.7
Трактортой	0.5	0.5	0.5	0.6	130.3
<b>Улсын дүн:</b> Цахилгаан үүсгүүртэй	82.8	87.8	82.0	84.2	102.6
Телевизортой	75.2	80.7	74.4	74.1	99.5
Машинтай	27.8	31.3	28.2	38.4	136.1
Мотоциклтой	41.7	48.3	43.2	47.2	109.4
Трактортой	1.7	1.8	2.4	3.3	136.0

**Нийт болон хээлтэгч мал, бойжуулсан төл.** Аймгийн нийт малын тоо 2010–2013 онуудад жилд дунджаар 8.0 хувиар өссөөр, 2013 оны жилийн эцэст малын тоо 2.5 сая толгойд хүрсэн байна. Малын тоо тэмээнээс бусад дөрвөн төрөл дээрээ өссөний дотор адуу 55.0 мянга, үхэр 44.0, хонь 255.4, ямаа 159.1 мянгаар нэмэгджээ. Түвшинширээ, Баруун–Урт, Мөнххаан, Уулбаян, Халзан сум малынхаа тоог 2010–2013 оны жилд дунджаар 10.1–14.3 хувиар өсгөсөн байна.

*ХҮСНЭГТ 12.3 АЙМГИЙН МАЛЫН ТОО, мянган толгой*

Малын төрөл	1990	2000	2010	2011	2012	2013	2013/2012%
Бүгд	1004.7	1492.5	1979.8	2081.4	2280.6	2491.4	109.2
Тэмээ	15.9	12.2	10.9	10.7	9.8	8.9	91.3
Адуу	118.2	192.2	148.1	164.9	183.6	203.1	110.6
Үхэр	132.2	209.6	128.0	136.7	151.1	172.0	113.8
Хонь	602.9	717.3	961.2	992.0	1090.8	1216.6	111.5
Ямаа	135.4	361.1	731.7	777.2	845.3	890.8	105.4


1990–2013 оны малын тооны сумаарх мэдээлэл хавсралт 12.1.1–д  
Малын тооны 2012–2013 оны багаарх мэдээлэл хавсралт 12.2.2–т

2013 оны аймгийн нийт малын тоог 1990 оныхтой зэрэгцүүлэхэд 2.5 дахин өссөний дотор ямааны тоо 6.6 дахин, хонь 2 дахин, адуу 1.7, үхрийн тоо 1.3 дахин нэмэгдэж, харин тэмээний тоо 44 хувиар буурсан байна.


Аймгийн малын тооны олон жилийн динамикийг харахад түүний өөрчлөлтөд нийгмийн өөрчлөлтөөс гадна цаг агаарын хүчин зүйл хүчтэй нөлөөлж байна. 1990–ээд оны эхээр мал хувьчилсаны дараа малын тооны тодорхой өсөлт гарсан боловч, 2001, 2002, 2010 оны өвөл–хаврын зуд малын тоог ихээхэн бууруулсан байна. Энэ хандлага бүх төрлийн малд ажиглагдсан бөгөөд зудны дараа түргэн өсөлттэй ямаа, хонь хурдан өссөн байна. Ноолуурын үнийн өсөлтөөс шалтгаалан ямаагаа түлхүү өсгөх хандлага байна.

*ЗУРАГ 12.2 АЙМГИЙН МАЛЫН ТООНЫ ӨСӨЛТ, БУУРАЛТ, мян.толгой*

*А. Хонь, ямаа*




## Б. Тэмээ, адуу, үхэр



2013 оны байдлаар хамгийн олон малтай сумд бол Баяндэлгэр (аймгийн дүнд эзлэх хувь–13.3%), Баруун–Урт (10.9%), Мөнххаан (10.7%), Түвшинширээ (10.2%) байна. Цөөн малтай сумд бол Түмэнцогт (2.9%), Асгат (4.1%) байна.

ЗУРАГ 12.3 АЙМГИЙН НИЙТ МАЛД СУМДЫН ЭЗЛЭХ ХУВЬ, 2013 оны байдлаар



## ХҮСНЭГТ 12.4 СУМДЫН НИЙТ МАЛЫН ТОО

Үзүүлэлтүүд	1990	2000	2010	2011	2012	2013	2013/2012%
Асгат	55861	79636	95935	91935	98387	102451	104.1
Баяндэлгэр	143586	203610	269001	271772	295839	330256	111.6
Дарьганга	63797	100310	134203	135653	137198	142608	103.9
Мөнххаан	77515	132619	187089	215419	243489	266517	109.5
Наран	57819	73394	105855	96082	98346	109091	110.9
Онгон	109913	158117	184682	187041	207014	228517	110.4
Сүхбаатар	73912	114313	159751	168313	186850	198188	106.1
Түвшинширээ	81763	103610	171570	196167	216595	254510	117.5
Түмэнцогт	32269	53973	58227	67737	71224	71522	100.4
Уулбаян	100514	126223	145321	158230	177073	201089	113.6
Халзан	54266	80803	88815	96984	109680	118438	108.0
Эрдэнэцагаан	122683	142029	197991	193113	198929	197201	99.1
Баруун–Урт	30759	123835	181351	202958	239957	271035	113.0
ДҮН	1004657	1492472	1979791	2081404	2280581	2491423	109.2


Өмнөх жилтэй харьцуулахад Эрдэнэцагаанаас бусад бүх сум малаа 0.4–17.5 хувиар өсгөсөн байна. Малаа 17.5 хувиар өсгөсөн сум бол Түвшинширээ сум байна.

2010 онтой харьцуулахад мөн Эрдэнэцагаанаас бусад бүх сум малаа 6.3–49.5 хувиар өсгөсөн байна. Малаа 49.5 хувиар өсгөсөн сум бол Баруун–Урт сум байна.

2000 онтой харьцуулахад бүх сум малаа 28.6 хувиас 2.0 дахин өсгөсөн байна. Малаа 2.0 дахин өсгөсөн сум нь Мөнххаан сум байна.

Хувьчлалаас өмнөх 1990 онтой харьцуулахад бүх сум малаа 1.6–8.8 дахин өсгөсөн байна. Малаа 8.8 дахин өсгөсөн сум нь Баруун–Урт сум байна.

ЗУРАГ 12.4 СУМДЫН НИЙТ МАЛЫН ТООНЫ БҮЛЭГЛЭЛТ



ХҮСНЭГТ 12.5 СУМДЫН СҮРГИЙН БҮТЭЦ


Сум	Бүтээгдэ- хүүнээр тооцсон хонин толгой, мянга	Үүнээс хувиар: тэмээ	адуу	үхэр	хонь	ямаа	Голлох салбарын тоо
Баруун–Урт	459.6	0.4	15.7	34.3	27.8	21.8	Олон салбартай
Асгат	191.8	0.7	19.3	37.8	24.1	18.1	Олон салбартай
Баяндэлгэр	530.9	0.5	10.5	34.4	30.1	24.4	Олон салбартай
Дарьганга	277.9	0.4	15.2	43.5	24.9	16.1	2 салбартай
Мөнххаан	415.9	0.6	14.3	29.4	31.1	24.7	Олон салбартай
Наран	196.9	0.6	10.6	42.1	27.9	18.8	2 салбартай
Онгон	378.4	0.9	11.2	35.7	33.8	18.4	2 салбартай
Сүхбаатар	325.1	1.4	16.7	30.5	32.5	18.9	Олон салбартай
Түвшинширээ	378.0	1.2	10.2	28.3	31.7	28.6	Олон салбартай
Түмэнцогт	140.5	0.7	20.4	39.9	22.1	17.0	Олон салбартай
Уулбаян	302.3	1.3	11.5	28.1	35.9	23.1	Олон салбартай
Халзан	193.8	0.7	13.8	33.1	32.1	20.4	Олон салбартай
Эрдэнэцагаан	387.2	0.6	20.6	39.7	19.1	20.1	Олон салбартай

Сумын байгаль–цаг уурын нөхцөлд илүү зохицсон, сумын мал аж ахуйн үйлдвэрлэл, борлуулалтын гол эх үүсвэр болж буй 1–2 салбар тухайн сумын мал аж ахуйн төрөлжилт, үйлдвэрлэлийн хэв шинжийг тодорхойлно. Үүнийг илэрхийлэгч үзүүлэлт нь мал аж ахуйн нийт ба таваарын бүтээгдэхүүнийг харгалзан ижил нэгжид шилжүүлсэн малын толгойн тооны бүтэц байна. Бэлчээрийн мал аж ахуйн салбарууд нь үйлдвэрлэлийн бүх нөөцөөрөө (бэлчээр, ус, нэмэгдэл тэжээл, хүн хүч) өрсөлдөх салбарууд учраас төрөлжилт гүнгийрэх тусмаа сайн гэж үздэг.


Арга зүйн хувьд нэг салбар дангаараа 50 хувиас дээш бол нэг салбараар төрөлжсөн, хоёр салбар нийлээд 67 хувиас дээш бол хоёр салбараар төрөлжсөн, эдгээр нөхцөл бүрдээгүй бол олон салбартай, төрөлжөөгүй гэж үздэг. Тус аймагт нэг салбараар төрөлжсөн сум байхгүй, хоёр салбараар төрөлжсөн сум 3 (Дарьганга, Наран, Онгон) байна. Хоёр салбараар төрөлжсөн эдгээр сумдын үйлдвэрлэлийн чиглэл: үхэр–хонины аж ахуй байна.

Аймгийн нийт сумдад тодорхой тооны тэмээ байгаа боловч Говийн бүсэд хамаардаг баруун өмнө талд орших Түвшинширээ, Уулбаян, Онгон, Сүхбаатар сумд харьцангуй олон, 1000–1300 тэмээтэй байна.


ЗУРАГ 12.5 АЙМГИЙН МАЛ АЖ АХУЙН ГОЛ САЛБАР–ТЭМЭЭНИЙ АЖ АХУЙН БАЙРШИЛ, сумаар




ЗУРАГ 12.6 АДУУНЫ АЖ АХУЙН БАЙРШИЛ, сумаар




ЗУРАГ 12.7 ҮХРИЙН АЖ АХУЙН БАЙРШИЛ, сумаар



ЗУРАГ 12.8 ХОНИНЫ АЖ АХУЙН БАЙРШИЛ, сумаар



ЗУРАГ 12.9 ЯМААНЫ АЖ АХУЙН БАЙРШИЛ, сумаар



Адуу нийт суманд тархсан боловч, нягтшилаараа Эрдэнэцагаан, Баруун-Урт, Мөнххаан, Баяндэлгэр, Сүхбаатар суманд илүү олон, толгойн тоо нь 18.7–27.3 мянга байна.

Үхэр нийт сумдын нутгаар тархсан боловч, Баяндэлгэр, Баруун-Урт, Эрдэнэцагаан, Онгон суманд илүү олон, толгойн тоо нь 16.2–21.8 мянга байна.

Хонь нийт сумдын нутгаар тархсан боловч, нягтшилаараа Баяндэлгэр, Мөнххаан, Онгон, Баруун-Урт, Түвшинширээ, Уулбаян, Сүхбаатар суманд илүү олон, толгойн тоо нь 105.7–160.0 мянга байна.

Ямаа нийт сумдын нутгаар тархсан боловч, нягтшилаараа Баяндэлгэр, Түвшинширээ, Мөнххаан, Баруун-Урт суманд илүү олон, толгойн тоо нь 99.3–128.5 мянга байна.

**Хээлтэгч мал.** Аймгийн дүнгээр 2013 оны жилийн эцэст 1089.2 мянган толгой хээлтэгч мал тоологдов.

#### ХҮСНЭГТ 12.6 ХЭЭЛТЭГЧ МАЛЫН ТОО

Үзүүлэлтүүд	2010	2011	2012	2013	2013/2012%
Бүгд	858.7	903.6	994.1	1089.2	109.6
Ингэ	3.8	3.7	3.5	3.4	96.2
Гүү	43.2	48.0	53.8	60.5	112.4
Үнээ	48.8	53.2	59.0	66.1	112.0
Эм хонь	438.6	454.8	500.5	560.0	111.9
Эм ямаа	324.2	343.9	377.4	399.3	105.8

Нийт хээлтэгчийн 2010–2013 оны жилийн дундаж өсөлт 8.3 хувь, гүүнийх 11.9 хувь, үнээний 10.6 хувь, эм хониных 8.5 хувь, эм ямааных 7.19 байв. Харин ингэний тоо жилд 3.6 хувиар буурчээ.

2013 оны байдлаар улсын хэмжээний нийт малын 43.7 хувийг хээлтэгч мал эзэлж байна. Аймгийн нийт малын 43.7 хувийг хээлтэгч мал эзэлж байгаа бөгөөд адуун сүргийн 29.8 хувь, үхэр сүргийн 38.4 хувь, тэмээн сүргийн 38.2 хувь, хонин сүргийн 46.0 хувь, ямаан сүргийн 44.8 хувийг тус тус эзэлж байна.

#### ХҮСНЭГТ 12.7 СҮРЭГТ ХЭЭЛТЭГЧ МАЛЫН ЭЗЛЭХ ХУВЬ

Үзүүлэлтүүд	2010	2011	2012	2013
Бүгд	43.4	43.4	43.6	43.7
Гүү	34.9	34.6	35.7	38.2
Үнээ	29.2	29.1	29.3	29.8
Ингэ	38.1	38.9	39.0	38.4
Эм хонь	45.6	45.8	45.9	46.0
Эм ямаа	44.3	44.2	44.6	44.8

Баяндэлгэр сум нийт хээлтэгчийн тоо, түүний дотроос үнээ, эм хонь, эм ямааны тоогоор аймагтаа тэргүүлж байна. Ингэний тоогоор аймагтаа Сүхбаатар сум, гүүний тоогоор Эрдэнэцагаан сум тэргүүлж байна.

## ХҮСНЭГТ 12.8 СУМДЫН ХЭЭЛТЭГЧИЙН ТОО, 2013

Сум	Бүгд	Ингэ	Гүү	Үнээ	Эм хонь	Эм ямаа
Баруун-Урт	122367	193	7585	7391	60551	46647
Асгат	38746	115	3375	3000	18477	13779
Баяндэлгэр	139397	298	5686	8555	70655	54203
Дарьганга	61389	121	4212	5373	31161	20522
Мөнххаан	120005	283	6361	5571	60490	47300
Наран	47978	142	2119	3968	25668	16081
Онгон	102632	354	4062	6256	60357	31603
Сүхбаатар	86370	469	5490	4357	48482	27572
Түвшинширээ	111249	468	3777	5015	54821	47168
Түмэнцогт	32323	99	3040	2576	15182	11426
Уулбаян	90173	450	3489	3950	50831	31453
Халзан	50703	142	2914	2941	28389	16317
Эрдэнэцагаан	85893	255	8349	7121	34949	35219
АЙМГИЙН ДҮН	1089225	3389	60459	66074	560013	399290

**Бойжуулсан төл.** Тус аймаг 2013 онд 853.3 мянган төл бойжуулсны дотор 442.2 мянган хурга, 321.5 мянган ишиг, 47.7 мянган тугал, 40.5 мянган унага, 1.5 мянган ботго бойжуулсан нь өнгөрсөн жилийнхээс унага, тугал, хурга, ишиг 11.0–28.4 хувиар нэмэгдэж ботго 8.0 хувиар буурсан байна.

 ХҮСНЭГТ 12.9 БОЙЖУУЛСАН ТӨЛИЙН ТОО  
 А. Аймгийн дүн, мянга

	1990	2000	2010	2012	2013	2013/2012%
Бүгд	384.0	432.9	656.2	786.1	853.3	108.5
Ботго	1.8	1.1	1.7	1.8	1.5	83.3
Унага	18.4	33.6	29.9	39.3	40.5	103.1
Тугал	36.9	56.9	38.4	45.9	47.7	104.0
Хурга	275.4	232.8	335.1	402.7	442.2	110.0
Ишиг	51.5	108.6	251.0	296.5	321.5	108.4

## Б. Сумаар, 2013

Сум	Бүгд	Ботго	Унага	Тугал	Хурга	Ишиг
Баруун-Урт	97082	92	5400	6191	47495	37904
Асгат	37508	65	2396	2438	18667	13942
Баяндэлгэр	108252	110	3575	5676	55483	43408
Дарьганга	52354	48	3001	3756	28581	16968
Мөнххаан	94822	147	4473	4037	48821	37344
Наран	36617	70	1664	2986	19044	12853
Онгон	66312	172	1865	2949	40856	20470
Сүхбаатар	70672	174	3208	3130	40045	24115
Түвшинширээ	85345	222	2869	3836	43219	35199
Түмэнцогт	24677	40	2133	2010	11708	8786
Уулбаян	64750	185	2468	2284	36181	23632
Халзан	44172	58	1964	2344	23935	15871
Эрдэнэцагаан	70699	97	5448	6031	28126	30997
АЙМГИЙН ДҮН	853262	1480	40464	47668	442161	321489

Баяндэлгэр сум нийт бойжуулсан төлийн тоо, түүний дотроос хурга, ишигний тоогоор аймагтаа тэргүүлж байна. Бойжуулсан ботгоны тоогоор Түвшинширээ, унаганы тоогоор Эрдэнэцагаан сум, тугалын тоогоор Баруун-Урт сум тэргүүлж байна.

2013 онд улсын дундажаар 100 эхээс 47 ботго, 79 унага, 81 тугал, 88 хурга, 85 ишиг бойжуулсан бол Сүхбаатар аймаг 42 ботго, 75 унага, 81 тугал, 88 хурга, 85 ишиг бойжуулсан байна. 100 эхээс бойжуулсан ботгоны тоогоор Асгат, унаганы тоогоор Түвшинширээ, тугалын тоогоор Эрдэнэцагаан, хурга, ишигний тоогоор Асгат сум аймагтаа тэргүүлсэн байна.

## ХҮСНЭГТ 12.10 100 ЭХЭЭС БОЙЖУУЛСАН ТӨЛ

## А. Аймгийн дундаж

	1990	2000	2010	2012	2013	Зүүн бүс, 2013
Бүгд	84	71	85	87	86	83
Унага	61	64	76	82	75	74
Тугал	72	72	88	86	81	81
Ботго	36	29	48	47	42	42
Хурга	88	73	86	89	88	85
Ишиг	89	71	84	86	85	82

## Б. Сумаар, 2013 он

Сум	Бүгд	Ботго	Унага	Тугал	Хурга	Ишиг
Баруун–Урт	90	42	81	102	92	87
Асгат	89	48	75	85	92	90
Баяндэлгэр	86	37	66	74	88	88
Дарьганга	86	33	72	72	95	81
Мөнххаан	87	51	84	86	89	86
Наран	84	44	86	85	85	84
Онгон	76	46	50	54	81	75
Сүхбаатар	90	41	77	85	92	91
Түвшинширээ	91	50	90	86	96	87
Түмэнцогт	76	33	79	87	76	74
Уулбаян	83	41	81	66	85	84
Халзан	92	34	86	94	92	93
Эрдэнэцагаан	81	34	69	85	81	83
АЙМГИЙН ДҮН	86	42	75	81	88	85

**Сум, багийн дундаж үзүүлэлт.** Улсын хэмжээнд нэг сум дундажаар 440 малчин өрх, 866 малчин, 135.8 мянган малтай байгаа бол Сүхбаатар аймгийн нэг сум дундажаар 497 малчин өрх, 1057 малчин, 191.6 мянган малтай байна.

## ХҮСНЭГТ 12.11 СУМ, БАГИЙН ДУНДАЖ ҮЗҮҮЛЭЛТ, 2013

Үзүүлэлт	Нэг сумын дундаж		Нэг багийн дундаж	
	Улс	Сүхбаатар аймаг	Улс	Сүхбаатар аймаг
Малчин өрх	440	497	90	97
Малчны тоо	866	1057	177	205
Малын тоо (мянган толгой)	135.8	191.6	28.1	37.2
Тэмээ	1.0	15.6	0.2	3.0
Адуу	7.8	13.2	1.6	2.6
Үхэр	8.6	0.7	1.8	0.1
Хонь	60.4	93.6	12.5	18.2
Ямаа	58.3	68.5	12.1	13.3

Сүхбаатар аймгийн Баяндэлгэр, Баруун–Урт, Мөнххаан зэрэг 9 сум улсын дундажаас олон буюу 142.6–330.3 мянган малтай, бусад 4 сум (Түмэнцогт, Асгат, Наран, Халзан) улсын дундажаас цөөн буюу 71.5–118.4 мянган малтай байна. Аймгийн сумдаас улсад дээгүүр байранд байгаа нь адууны тоогоор Эрдэнэцагаан сум 3–т, Баруун–Урт сум 5–д, үхрийн тоогоор Баяндэлгэр сум 16–д, хонины тоогоор Баяндэлгэр сум 8–д, ямааны тоогоор мөн Баяндэлгэр сум 10–дугаарт орж байна.

*ХҮСНЭГТ 12.12 УЛСЫН НИЙТ 330 СУМЫН ДОТОР ЭЗЛЭХ БАЙР, 2013 оны байдлаар*

Сум	Бүх малын тоо	Тэмээгээр	Адуугаар	Үхрээр	Хониор	Ямаагаар
Баяндэлгэр	3	85	18	16	8	10
Баруун-Урт	15	117	5	28	26	37
Мөнххаан	16	89	12	53	24	33
Түвшинширээ	24	66	53	81	31	25
Онгон	35	77	40	40	25	108
Уулбаян	57	69	64	112	41	106
Сүхбаатар	61	64	22	95	42	137
Эрдэнэцагаан	64	91	3	30	100	77
Дарьганга	133	152	42	56	105	208
Халзан	176	130	98	149	128	233
Наран	197	144	141	120	155	241
Асгат	211	136	56	128	185	248
Түмэнцогт	285	162	87	167	253	285

Манай улсын нийт 1592 багийн дундаж малын тоо 28.1 мянга байхад Сүхбаатар аймгийн 67 баг дундажаар 37.2 мянган толгой малтай байна.

**Хамгийн олон малтай сум.** Улсын хэмжээнд 2013 оны байдлаар Архангай аймгийн Эрдэнэмандал сум улсад хамгийн олон малтай, мөн хамгийн олон хоньтой, Булганы Сайхан сум хамгийн олон адуутай, Архангайн Өндөр-Улаан сум хамгийн олон үхэртэй, Өмнөговийн Ханбогд сум хамгийн олон тэмээтэй, Өвөрхангайн Богд сум хамгийн олон ямаатай байна.

Сүхбаатар аймгийн хувьд Баяндэлгэр сум хамгийн олон малтай, мөн хамгийн олон үхэртэй, хоньтой, ямаатай, Эрдэнэцагаан сум хамгийн олон адуутай, Сүхбаатар сум хамгийн олон тэмээтэй байна.

*ХҮСНЭГТ 12.13 ХАМГИЙН ОЛОН МАЛТАЙ СУМ, 2013*

Үзүүлэлт	Улсын хэмжээгээр		Сүхбаатар аймаг	
	Аймаг, сум	Малын тоо, мян тол	Сум	Малын тоо, мян тол
Бүх малаар	АР, Эрдэнэмандал	372.3	Баяндэлгэр	330.3
Тэмээгээр	ӨМ, Ханбогд	21.2	Сүхбаатар	1.3
Адуугаар	БУ, Сайхан	34.5	Эрдэнэцагаан	27.3
Үхрээр	АР, Өндөр-Улаан	41.6	Баяндэлгэр	21.8
Хониор	АР, Эрдэнэмандал	240.4	Баяндэлгэр	160.0
Ямаагаар	ӨВ, Богд	202.0	Баяндэлгэр	128.5

**Хамгийн олон малтай баг.** Төв аймгийн Лүн сумын Өгөөмөр баг улсдаа хамгийн олон малтай, мөн хамгийн олон хоньтой, Сүхбаатар аймгийн Баруун- Урт сумын 8-р баг хамгийн олон адуутай, Архангай аймгийн Чулуут сумын Халуун-Ус баг хамгийн олон үхэртэй, Өмнөговийн Ханбогд сумын Баян баг хамгийн олон тэмээтэй, Хөвсгөл аймгийн Галт сумын Зүрх баг хамгийн олон ямаатай байна.

## ХҮСНЭГТ 12.14 ХАМГИЙН ОЛОН МАЛТАЙ БАГ, 2013

Үзүүлэлт	Улсын хэмжээгээр		Сүхбаатар аймаг	
	Аймаг, сум	малын тоо, мян тол	Сум, баг	малын тоо, мян тол
Бүх малаар	ТӨ, Лүн, Өгөөмөр	120.5	Баруун-Урт, 8-р баг	109.6
Тэмээгээр	ӨМ, Ханбогд, Баян	8.5	Сүхбаатар, Хулгар баг	0.6
Адуугаар	СҮ, Баруун-Урт, 8-р баг	9.0	Баруун-Урт, 8-р баг	9.0
Үхрээр	АР, Чулуут, Халуун-Ус	12.8	Баруун-Урт, 8-р баг	8.0
Хониор	ТӨ, Лүн, Өгөөмөр	67.9	Баруун-Урт, 8-р баг	50.9
Ямаагаар	ХӨ, Галт, Зүрх	56.1	Баруун-Урт, 8-р баг	41.6

Сүхбаатар аймгийн хувьд Баруун-Урт сумын 8-р баг хамгийн олон малтай, мөн хамгийн олон адуутай, үхэртэй, хоньтой, ямаатай, Сүхбаатар сумын Хулгар баг хамгийн олон тэмээтэй байна.

**Тэжээвэр амьтад.** 2013 онд гахай 77, шувуу 214, зөгийн бүл 8 тоологджээ. Ихэнх аймгуудад сүүлийн жилүүдэд тэжээвэр амьтдын тоо өсч байна.

## ХҮСНЭГ 12.15 ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТОО, ТОЛГОЙ

Үзүүлэлт	2000	2010	2012	2013	2013/2012%
Гахай	35	177	135	77	57.0
Шувуу	385	1327	279	214	76.7
Зөгий, бүл	2	-	-	8	-
Туулай	-	-	2	1	50.0

**Хашаа, худгийн хангамж.** ҮСХ-ноос хашаа, худгийн тооллогыг 3 жил тутамд мал тооллоготой хамтруулан явуулж байгаа бөгөөд сүүлчийн тооллогыг 2012 онд хийв.

## ХҮСНЭГТ 12.16 ХАШАА, ХУДГИЙН ТОО

Үзүүлэлт	1990	2006	2009	2012	2012/1990 %	
					Хувь	(+,-)
Хашааны тоо-бүгд	1965	2490	3732	3682	186.1	1717
Багтаамж (мян.тол)	934.5	1125.8	1584.0	1849.2	197.9	914.7
Хашааны хангамж, %: бодын	24.5	25.0	27.1	55.9	228.2	31.4
богийн	71.0	83.0	101.1	85.6	120.6	14.6
Худгийн тоо-бүгд	2920	2206	3206	2296	78.6	-624
инженерийн	1526	374	1731	539	35.3	-987
энгийн уурхайн	1394	1832	1475	1757	126.0	363
Усан сан	73	...	...	9	12.3	-64

Сүхбаатар аймагт 2012 онд 3682 хашаа, үүнээс 2408 бодын, 1274 богийн хашаа, нийт 2296 худаг, үүнээс инженерийн 539, энгийн уурхайн 1843 худаг, 9 усан сан тоологджээ.

**Бэлчээрийн хүрэлцээ.** Улсын дундажаар 2013 онд 100 бэлчээрийн талбайд 66 хонин толгой мал ногдож байхад, Сүхбаатар аймагт 59 хонин толгой буюу 7-оор цөөн байна.


Бэлчээрийн ачаалал хамгийн өндөр байгаа сум бол Баруун-Урт сум (аймгийн төв), Түмэнцогт, Түвшинширээ, Дарьганга, Наран сумд байна. Харин бэлчээрийн даац сайтай, цаашид мал өсгөх боломжтой сум бол юуны өмнө Эрдэнэцагаан, Асгат сумд болно.

Хонин толгойд ногдож буй нэмэгдэл тэжээлийн хэмжээ 2.1 кг байгаа нь хадлангийн нөөц сайтай тус аймгийн хувьд хангалтгүй үзүүлэлт юм.

### ХҮСНЭГТ 12.17 БЭЛЧЭЭРИЙН ДААЦ, ТЭЖЭЭЛИЙН ХҮРЭЛЦЭЭ

Үзүүлэлт	2010	2011	2012	2013	2013/2012%
100 га бэлчээрийн талбайд ногдох хонин толгой:					
Улсын дундаж	48	60	60	66	111.1
Зүүн бүс	36	50	50	54	108.0
Сүхбаатар аймаг	45	53	53	59	111.3
Нэг хонин толгойд ногдох нэмэгдэл тэжээлийн нэгж, кг:					
Улсын дундаж	5.8	11.0	9.3	8.2	87.9
Зүүн бүс	6.2	3.3	2.5	2.1	83.3
Сүхбаатар аймаг	1.4	3.3	2.5	2.1	84.0

ЗУРАГ 12.10 СУМДЫН БЭЛЧЭЭРИЙН АЧААЛАЛ



## ГАЗАР ТАРИАЛАН

<b>Газар тариалан</b>	Газар тариалан эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс тариалсан талбай, ургацын мэдээг баг, хороод авч сум/дүүрэгт нэгтгэн, аймаг/нийслэлийн статистикийн хэлтэс/газарт хүргүүлж, улмаар ҮСХ–нд нэгтгэн боловсруулж байна.
Манай улсад гол төлөв үр тариа, төмс, хүнсний ногоо, малын тэжээлийн ургамал зэргийг тарьж ургуулдаг бөгөөд тэдгээрийг тариалсан талбай, хураасан ургац, нэг га талбай тутмаас хураан авсан ургацын хэмжээг улс, орон нутгийн түвшинд тодорхойлно.	
<b>Хөдөө аж ахуйн газар</b>	Хөдөө аж ахуйн газарт бэлчээр, хадлан, тариалан, атаршсан газар, хөдөө аж ахуйн барилга байгууламжийн дэвсгэр, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хэрэгцээнд зориулсан бусад газрыг хамруулна (Газрын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалт). Тариалангийн талбайд хөдөө аж ахуйн ургамал тариалсан талбайг оруулах бөгөөд тухайн жилд үр суулгасан газрын нийт хэмжээгээр тодорхойлно.
